

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

**2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-4
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	5-50

---

**1.Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.27-ны өдөр өргөн ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/**

5-15

**2.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

15-50

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
4 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 52 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Анар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, О.Батнайрамдал, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, Ч.Лодойсамбуу, М.Энхцэцэг;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ш.Бямбасүрэн, А.Ундраа, О.Цогтгэрэл.

**Нэг.Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2026.03.27-ны өдөр өргөн ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантулга, мөн хэлтсийн мэргэжилтэн Д.Ариунтуул, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Лувсанцэрэн, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Судалгаа хөгжлийн төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн албаны зөвлөх Л.Батмөнх, референт М.Мандхай нар байлцав.

Зээлийн болон хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Н.Батсүмбэрэл, Г.Очирбат, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Сангийн сайд

З.Мэндсайхан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Лувсанцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Х.Булгантуяа, Р.Сэддорж нар үг хэлэв.

**Р.Сэддорж:** Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хоорондын “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 4  
Бүгд: 19  
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар 2025.12.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Хуулийн газрын Эрх зүйн бодлого, судалгааны хэлтсийн дарга Б.Эрдэнэхуяг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, мөн хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн, Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул, мөн хоршооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Хадгаламж зээлийн хоршооны газрын ахлах зөвлөх Д.Соёлмаа, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Б.Ариунболд, мөн корпорацийн Эрсдэлийн удирдлага, комплайнс, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан хэлтсийн захирал Б.Амарбат, Хадгаламжийн даатгалын корпорацийн хуульч Б.Хулан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн албаны зөвлөх Л.Батмөнх, референт М.Мандхай нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

*Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд 11 цаг 37 минутаас 11 цаг 47 минутад хуралдааныг даргалав.*

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Г.Очирбат, П.Батчимэг, Б.Пунсалмаа, Б.Жаргалан, Л.Соронзонболд, Н.Батсүмбэрэл,

Д.Энхтүвшин, П.Сайнзориг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Монголбанкны Хуулийн газрын Эрх зүйн бодлого, судалгааны хэлтсийн дарга Б.Эрдэнэхуяг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, мөн хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга Ц.Алтантуул, мөн хоршооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, П.Сайнзориг, М.Мандхай, Н.Батсүмбэрэл, Р.Сэддорж нар үг хэлэв.

**Р.Сэддорж:** 1.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 6  
Бүгд: 20  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ

2.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 7  
Бүгд: 20  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Санхүүгийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 7  
Бүгд: 20  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 8  
Бүгд: 20  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 7

Бүгд: 20  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 7  
Бүгд: 20  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 7  
Бүгд: 20  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 7  
Бүгд: 20  
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 13 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 31 минут үргэлжилж, 31 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 64.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 23 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим  
10 цаг 52 минут.

### **ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Ренчиндоржийн Батболд, Пүрэвийн Батчимэг, Пүрэвжавын Ганзориг, Батбаярын Жаргалан, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Бадрахын Найдалаа, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Болдын Уянга, Саруулсайханы Цэнгүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд оролцож байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хороодын гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 58.1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулах “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх. Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

2.Санхүүгийн хоршооны тухай хууль/Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа, Заяабал нараас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орьё.

**Хэлэлцэх асуудал 1.Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулах “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.**

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн Сангийн сайд Мэндсайхан танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

**3.Мэндсайхан:** Эдийн засгийн байнгын хорооны дарга болон Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл нь Шинэ сэргэлтийн бодлого Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан өндөр ач холбогдолтой төсөл бөгөөд тус төслийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банкны эх үүсвэрээр санхүүжүүлэхээр зээлийн хэлэлцээрийг хийгээд байна.

Энэхүү төслийг Германы Сэргээн босголтын зээлийн банкнаас олгох 17 сая еврогийн зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх бөгөөд эргэн төлөх хугацаа 30 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 10 жил, жилийн 2 хувийн хүүтэй, нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл болно.

Тус зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ бөгөөд зээлийн хөрөнгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөсөн.

Төслийн хүрээнд СБД-ийн 1 дүгээр хороонд шинээр дэд станц, хос цахилгаан дамжуулах кабель шугам барьж, одоо байгаа Туул дэд станцыг өргөтгөх ажлыг гүйцэтгэх бөгөөд ингэснээр хотын төвийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул болон Баянзүрх 5 дугаар дүүргийн, 14 дүгээр хорооны 1 дүгээр зэргийн хэрэглэгчид болох Улсын 1 дүгээр төв эмнэлэг, 2 дугаар төв эмнэлэг, Өргөө амаржих газар зэрэг нийт 11 мянган хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа дээшилж иргэн болон аж ахуйн нэгжүүдийг эрчим хүчээр тогтвортой хангах ач холбогдолтой юм.

Иймд Монгол Улс, Германы Сэргээн босголтын зээлийн банк хоорондын Төвийн бүсийн Цахилгаан дамжуулах түгээх сүлжээний эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шатын зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Баярлалаа.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Мэндсайхан Сангийн сайд, Б.Найдалаа Эрчим хүчний сайд, Б.Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лувсанцэрэн Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Дашдаваа “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, Лхагвадэмбэрэл “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Судалгаа хөгжлийн төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ариунтуул Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Соронзонболд гишүүн дээр тасалъя. Соронзонболд гишүүн.

**Л.Соронзонболд:** Энэ 2 дэд энэ 17 сая еврогийн зарцуулалт маань энэ 2 дэд станц дээрээ энэ 4км урт урт цахилгаан дамжуулах кабель шугам барьж байгаа өртөг нь зөвлөх үйлчилгээнд төлж байгаа зардлаараа гээд задаргааг нь танилцуулаач гэсэн ийм асуулт байна.

**Р.Сэддорж:** 2 номер.

**С.Тулга:** Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар Тулга. Гишүүний асуултад хариулъя. Энэ Өргөө дэд станцын барилга угсралтын ажилд нийт 6.7 сая евро, 110квт-ын кабелийн шугамын ажилд 8.9 сая евро, одоогийн байгаа Туул дэд станцын өргөтгөлд 355 мянган евро, тэгээд бусад 497.2 мянган евро гэсэн ийм задаргаа байгаа. Бусад дотор төслийн хэрэгжилтийн зөвлөх үйлчилгээ дотор зөвлөх үйлчилгээ, болзошгүй зардал гэсэн ийм хуваарилалттай байгаа гишүүн.

**Р.Сэддорж:** Соронзонболд гишүүн тодруулж асууя.

**Л.Соронзонболд:** Тэгэхээр 110квт-ын 4км цахилгаан дамжуулах шугам барихад 8.9 сая евро зарцуулах гэж байна гэсэн үг үү? Бид нар энэ яагаад энэ тухай асуугаад байна гэхээр Мандалговь, Өвөрхангай чиглэлийн 200 хэдэн километр 220-той шугам барихад километр нь бараг ингээд 970 сая төгрөг хавьцаа болоод байсан байхгүй юу. Тэгэхээр энэ дээр тодруулж асуух гээд. 8.9 сая евро 4км цахилгаан дамжуулах шугам барихад ийм их мөнгө зарцуулж байгаа юм уу? Энэ ямар үндэслэлтэй вэ?

**Р.Сэддорж:** Хариулт 4 номер.

**И.Лувсанцэрэн:** Эрчим хүчний яам Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Лувсанцэрэн. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Энэ дэд станц маань бол GIS буюу хийн тусгаарлагчтай 110 киловольтын дэд станц байгаа. 4 километр 110 киловольтын кабель шугам. Энэ маань газар доогуур явна. Трассын дагуу явах энэ бол хүндрэлтэй. Газар шорооны ажил хийгдэнэ. Ийм учраас бас энэ газар шороо болон энэ кабель шугамтай холбоотой өртгийн үнэ бол харьцуулалтаар ийм өндөр гарч байгаа гэдгийг хэлье.

**Р.Сэддорж:** Өөрийгөө танилцуулсан уу? Батсүмбэрэл гишүүнийг нэмье. Их бас товчхон хариулж байна шүү. Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Зээлийн хэлэлцээрийг бол дэмжиж байна. Тэгээд ер нь энэ Эрчим хүчний яамнаас асуугаадахъя. Эрчим хүчний эх үүсвэрийн найдвартай байдал, шугам сүлжээний найдвартай байдал ер нь хэр байгаа вэ Улаанбаатар хотын хувьд? Энэ 2026-2027 оны өвөл та нар хэр хязгаарлалт хийх гээд байгаа вэ? Үүнийгээ иргэд, олон түмэнд эрт танилцуулж хэлж болох уу? Төлөвлөгөөт болон бусад засвар үйлчилгээнүүдээ дулааны улиралд яаралтай хийж дуусгах тал дээр анхаарч байгаа юм бий юу? Тэгээд өвөл болохоор баахан тог салгадаг энэ байдлаа та нар засах уу? Тэгээд энэ байдлыг засахад чинь хэрэгтэй гэж бодож л энэ зээлийн хэлэлцээрийг дэмжээд байдаг. Харамсалтай нь байгаа байдал бахь байдгаараа байдаг бол мөн хэцүүеэ. Тэгээд энэ дээрээс хариулъя хариулт авъя.

**Р.Сэддорж:** Хариулт 4 номер.

**И.Лувсанцэрэн:** Эрчим хүчний яам Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Лувсанцэрэн. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол яах вэ бид өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаад эхэлсэн 3 сарын 15-наас эхлээд их засвар болон дунд засвар, урсгал засварын ажлыг бол хийгээд эхэлсэн. Та бүхэн мэдэж байгаа байх. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ болон орон нутгийн Эрдэнэт, Булганы цахилгаан түгээх сүлжээ, Баруун бүсэд орон нутгийн эрчим хүчний системийнхэн маань хуваарь гаргаад энэ их засвар, урсгал засварын ажлууд байвал гүйцэтгээд явж байгаа.

Бид хэд энэ өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах дээр онцгой анхаарал хандуулаад ажиллаж байна. Шинэ Засгийн газар байгуулагдсан. Энэтэй холбоотойгоор бас бид энэ өвөлжилтийг хэрхэн яаж давах вэ, богино хугацаанд энэ цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг оруулах боломж нь юу байна гэдгийг маргааш Засгийн газрын хуралдаанаар танилцуулахаар бэлтгэл ажил хангаад явж байна. Ялангуяа энэ дээр сэргээгдэх эрчим хүч буюу энэ батарей хуримтлуурын станцыг ямар боломжийн санхүүжилтийн эх үүсвэрээр шийдвэрлэж энэ өвлийг оргил ачаалалд нь бас ингэж оролцуулах боломж байна вэ гэдэг талаар судалгаа хийгдэж байна.

Ер нь бол яах вэ энэ жил 70мвт-ыг Сэлэнгэ аймгийн бас Сүхбаатар сумд баригдах 70мвт-ын дулааны цахилгаан станц/ДЦС/ ашиглалтад орно. 27-0 оны түвшинд бол 2429мвт-ын 7 эх үүсвэр ашиглалтад орж энэ 20 хувийн нөөцийг бүрдүүлэх боломж бүрдэх юм байгаа юм. Тэгэхээр 26-аас 27 оны нөхцөлд эрчим хүч хязгаарлахгүй байх ямар боломж байна гэдэг талаар судалгаа, тооцооны юмнуудаа бүгдийг нь бэлтгэл ажил хангаад явж байна.

Мөн дээрээс нь Оюу толгой уурхай маань бол БНХАУ-аас 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугамаар импортын цахилгаан эрчим хүчийг хангаж байгаа. Үүн дээр үүн дээр нэмэх нь Зэс Оюу буюу дэд станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, импортоор 70-80мвт-ыг авч төвийн бүсийн хэрэглээндээ бас энэ өвлийн оргил ачаалал авах энэ бэлтгэл ажлыг хангаад явж байна.

**Р.Сэддорж:** Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

**Н.Батсүмбэрэл:** Та нар мэдэж байгаа ч юм байхгүй л дээ. Бид нар мэдэж байгаа юм алга байна. Алга учраас асуугаад байгаа юм. Тэр хувиараа олон түмэнд өг өө Эрчим хүчний яам. Уг нь энэ Чойжилсүрэн сайд байхдаа хуралд суудаг байсан. Найдалаа сайд хааччихсан юм? Найдалаа сайд Эрчим хүчний яамны асуудлыг шийдэх гэж байгаа юм байгаа биз дээ, сайдыгаа дууд л даа та нар. Тэр сэргээгдэх эрчим хүчийг шийдэх нь зөв байгаад байгаа юм. Улаанбаатар хот чинь эрчим хүчний хомсдолд орчихсон, эрчим хүчний хүнд сурталд хүлүүлээд баглуулчихсан. Үүнийг шийдэж байгаа ганц арга нь сэргээгдэх эрчим хүч. Сая өвлийн тогны хязгаарлалтад ЧД-т 93 айл нарны эрчим хүчинд холбогдсон. Тэр 93 айл тогны хязгаарлалтад ороогүй шүү дээ. Улаанбаатар тог тасарчихсан байхад тэр 93 айл гэрэл чийдэнтэй байсан. Улаанбаатар хотын энэ гэр хорооллын 220 мянган айлыг та нар нарны финалтай болгочихмоор байгаа юм. Ингэж байж л эрчим хүчний хүнд суртлаас чөлөөлөх юм байгаа юм шүү дээ. Энийг тодруулаад хэлээдхээч.

**Р.Сэддорж:** Найдалаа гишүүн ирцдээ орчихсон байна. Байгаа сайд. Хариулт хэдэн номер вэ? 4 номер.

**И.Лувсанцэрэн:** Эрчим хүчний сайдын 3 сарын 2-ны өдөр энэ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс түгээх сүлжээнд холбогдох айл өрхүүдийг түгээх сүлжээнд нийлүүлэх ийм журмын зохицуулалт гарсан. Үүн дээр бол өнөөдрийн байдлаар үнэ тарифыг шинэчилж өгсөн. Мөн дээрээс нь 20квт хүртэл айл өрхүүдийг ямар нэгэн техникийн нөхцөл саадгүйгээр олгох, зөвхөн санал, зөвлөмжийн хүрээнд түгээх сүлжээнд холбогдох ийм нөхцөлийг бүрдүүлсэн.

20квт-аас дээш хүчин чадалтай айл өрхүүдийг бол техникийн нөхцөлийг хөнгөжүүлсэн журмаар олгох, энийг бол 28 хоногийн дотор шийдвэрлэх ийм зохицуулалтыг гарсан. 20квт хүртэл л бол зохицуулалтыг 10 хоногийн дотор ингэж шуурхай зохион байгуулахаар бол болсон.

Хоёр дахь нь гэх юм бол бас үнэ тарифыг нэмэгдүүлж.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулья.

**И.Лувсанцэрэн:** Журмын хүрээнд бол ямар нэгэн хүнд суртал байхгүй. Хөнгөвчилсэн. Үнэ тарифыг мөн нэмэгдүүлсэн байж байгаа. Өдрийн цагаар гэх юм бол 285 төгрөг киловатт цагаар нийлүүлэх, түгээх сүлжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн. Оргил ачааллын үеэр нийлүүлэх нөхцөлд 300 төгрөг киловатт цагаар нийлүүлэх ийм боломжийг бүрдүүлсэн гэсэн үг.

**Р.Сэддорж:** Очирбат гишүүнийг нэмье. Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Өдрийн мэнд. Ерөнхийдөө бол зээлийн энэ хүү их багатай юм байна лээ. Тэгээд 17 сая евро авах гэж байгаа 2 хувийн хүүтэй тэгэхээр нөхцөл бол их аятайхан байгаа дэмжмээр санагдаад байгаа. Тэгээд бодлогыг нь харахаар буруу болчихоод байгаа юм. 17 сая еврогоор 5 мянган өрхийг сэргээгдэх эрчим хүчээр, эрчим хүчийг нь 17-гоос 20квт хүртэлх нарны панел тавиад, батарей хураагууртай нь шийдээд өөрөө өөрийнхөө эрчим хүчийг хангаад төв рүү бас нийлүүлэх ийм боломж бололцоо байгаад байгаа юм. Энийг хий, хийгээч ээ гээд бид нар Улсын Их Хурлаас энэ 119 дүгээр тогтоолыг гаргаж өгсөн. Түрүүн хэн хариулаад байсан хэн байсан бэ нэр? Айн? Лувсанцэрэн хариулж байна. Хүнд суртал багасаж байна аа гэж байгаа юм.

Дүрэм, журмын хүрээнд бол багасаад байгаа. Яг амьдрал дээр бол багасахгүй байгаа шүү. Танай түгээхийнхэн чинь ажлаа хийхгүй байгаа юм. Одоо энэ сэргээгдэхээр энэ 20квт хүртэлх өөрийнхөө эрчим хүчийг станцыг ингээд шийдчихсэн иргэд эрчим хүчээ нийлүүлчхээд буцаагаад мөнгөө авч чадахгүй байна. 285 төгрөг 300 гэсэн 2 үнэ яваад байгаа юм. Нэг. Энийгээ Эрчим хүчний зохицуулах хороо хараарай. Яагаад гэхээр тануус аж ахуйн нэгжээс авахдаа 5, 6 зуун төгрөгөөр 1квт-ыг нь үнэлж аваад байдаг, иргэд нь өөрсдөө 20 хүртэл киловатт станц бариад улсдаа дэм больё гээд үйлдвэрлэж байгаа эрчим хүчээ өгөхөөр 285 төгрөгөөр авна гээд байдаг. Тэгээд бодлогын гажуудал гарчихсан байгаа шүү. Бид бол энэ утаанаасаа салъя, иргэд маань орлоготой больё, эрчим хүчнийхээ тусгаар тогтнолыг олъё гэсэн том бодлого зорилтын хүрээнд энэ Их Хурлын чиглэл өгөх 119 дүгээр тогтоолыг гаргасан байгаа. Энэний хэрэгжилт тун тааруу байгаа.

Тэгээд зээл мөнгө авах болохоороо орж ирээд ингээд 17, 8 сая еврогоор нь яриад байдаг. Яг иргэддээ очсон энэ чинь 4, 5 мянган айл өрхийн янданг нь буулгаад эрчим хүч станц өөрсдөө 20квт-ын станцтай болоод орлого олох бололцоог нь нээж өгье өө гэхээр энэ дээр ингээд хөдөлдөггүй байгаад байдаг шүү. Тэр манай эрчим хүчний салбарынхан энэ хүнд суртал байна уу байхгүй юу? Энэ 20квт-ын яг үйлдвэрлээд өнөөдөр иргэд мөнгөө авч чадахгүй байна аа гэсэн гомдол надаа ирээд байгаа юм. Тэр яг авч чадаж байгаа юу үгүй юү гэдэггүй юү гэдэг дээр хариулт авчихъя тэгээд тодруулъя.

**Р.Сэддорж:** Хэн хариулах вэ 7 номер.

**О.Хуягцогт:** Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. Гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний зохицуулах хорооноос үнэ, тарифын бодлогыг баталж байгаа. Тэгэхээр эцсийн хэрэглэгчид очиж байгаа тариф, үйлдвэрлэл, үйлдвэрлэгчийн тарифын зөрүүгээс эрчим хүчний салбарт бол бас ийм тарифын алдагдал үүсчхээд байгаа юм. Тэгэхээр 1 худалдан авагчийн загвар дээр бол яг энэ шалтгааны улмаас сэргээгдэх болон бусад импорт өндөр үнэтэй эрчим хүчний эх үүсвэрийг бид илүү ашиглаад байх тусам алдагдал үүсээд ингээд төлбөрийн чадваргүй болсон ийм нөхцөлд байгаа. Тэгэхээр энийг бол тарифын бодлогыг нь өөрчилж байж энэ асуудал нэг мөр шийдэгдэх юм. Тэгэхээр ийм хүндрэл бол бодитой байгаа.

**Р.Сэддорж:** Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Тэгээд харин ийм хүндрэл байгаа юм бол бодитой байгаа юм бол бодитой шийдээд өг л дөө. Тануус тэр аягүй өндөр үнэтэй аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хийчихдэг л юм байна лээ шүү дээ. Тэгээд тэр гэрээгээ хийлгэсэн компанитайгаа уулзаад үнэ өртгөө доошоо буулга л даа. Тэгээд тэрийгээ хийж чадахгүй байж иргэд нь 20квт хүртэл үйлдвэрлээд өгье гэхээр хямдхан аваад байдаг. Наад бодлого чинь болохгүй байна гээд хэлээд байгаа нь тэр шүү дээ. Тэгээд наадах чинь 10 хэдэн компани л байлаа шүү дээ. Тэр компанийнхаа нөхдүүдтэй уулзаад гэрээгээ шинэчилж хараад, одоо тухайн үеийн магадгүй 10, 15 жилийн өмнө бол технологи жоохон хүнд байсан. Орж ирэхэд хөрөнгө оруулалт өндөр байсан. Тэрийг нь ойлгож байгаа. Гэхдээ энэ чинь 10, 20 жил өнгөрчхөөд байна. Өртгөө аль хэзээний нөхчихсэн энэ чинь. Монголын энэ ард түмнээ бодъё л доо, иргэдээ бодъё л доо, эрчим хүчнийхээ бодлогыг зөв болгоё л доо. Энэ бүсчилсэн хөгжил гээд л үзэл баримтлал гаргаж ирээд л явсан. Тэрнийхээ дагуу бүсчлээд энэ эрчим хүчний асуудлаа шийдээд иргэд маань өөрсдөө эрчим хүчээ үйлдвэрлээд буцаагаад сар бүр мөнгөө авдаг болмоор байна шүү дээ. Тэгэхгүй иргэд.../минут дуусав./

**Р.Сэддорж:** 4 номер тодорхой хариулаарай гишүүдийн асуултад.

**И.Лувсанцэрэн:** Эрчим хүчний яам Лувсанцэрэн. Өмнөх журмын зохицуулалтаар жилийн эцсээр тухайн иргэний үйлдвэрлэж түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний үнэ төлбөрийг төлдөг журмын зохицуулалттай байсан. Сая 3 сард шинэчлэн тогтоосон шинэ журмаар сар бүр иргэдэд тухайн нийлүүлсэн цахилгаан эрчим хүчинд оногдох төлбөрийг нь төлөх ийм зохицуулалт өгсөн. Энийг бол тухайн салбар эрчим хүчний салбарт ажиллаж байгаа бас энэ түгээх сүлжээ компаниуддаа мэдэгдэл хүргүүлсэн. Мөн энэ сэргээгдэх эрчим хүчнээс түгээх сүлжээнд нийлүүлэх энэ журмын сурталчилгааг

орон нутгийн удирдлагуудтай нийлүүлээд түгээх сүлжээ компаниуд маань хамтраад хэрэгжүүлээд явж байгаа.

Тэгэхээр цаг хугацааны хувьд бол хөнгөвчилж өгсөн. Өртгийн тухайд бол мэдээж энэ зөвхөн хэрэглэгч өөрийн хэрэгцээндээ ашиглаад түгээх сүлжээнд.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Гүйцээгээд хариулчихъя 4 номер.

**И.Лувсанцэрэн:** Өөрийн хэрэгцээндээ ашиглаад илүүдлийгээ түгээх сүлжээнд нийлүүлэх ийм л техникийн зохицуулалт явж байгаа. Тэрнээсээ бол түгээх сүлжээнд нийлүүлээд өдрийн цагаар 285 төгрөг, оройн оргил ачааллаар 380 төгрөгийг ийм үнэ, тарифыг бол тогтоож өгсөн. Тэрнээс өшөө яг өрх, айл өрх ашиг олох зорилгоор энэ түгээх сүлжээнд нийлүүлэх ийм бол зарчим бол биш ээ гэдгийг бас та бүхэн ойлгоосой гэж хүсэж байна. Одоо яг энэ нийгэмд ийм ойлголт төрөөд байгаа байхгүй юу. Айл өрхөд суурилуулаад тэгээд буцаагаад ашиг олох. Эхлээд бол өөрийнхөө хэрэглээгээ хангах ёстой энэ хүн. Тэгээд түгээх сүлжээндээ илүүтэй нийлүүлээд тэндээсээ тодорхой хэмжээний энэ борлуулалтын орлого олох ийм боломж эрхийг л нээж өгсөн асуудал байгаа.

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй гэж үзэж байгаа учраас Очирбат гишүүн тодруулъя.

**Г.Очирбат:** Та хэд бол аягүй сайн ойлгосон байна шүү дээ. Энэ Их Хурлаас гарсан тогтоолыг, “Чиглэл өгөх” тогтоолыг. Тэгэхээр яг энийгээ бариад л цаашаа ажиллачхаарай. Доод шатдаа наадах чинь ажил хэрэг болохгүй байна. Очоод энэ түгээх газруудаас чинь би энэ сар эрчим хүч үйлдвэрлээд өөрийнхийгөө эхлээд хэрэглээгээ хангаж байна шүү дээ. Тэр бол хамгийн нэгд. Хангаад илүү гарсан хэдхэн киловаттынхаа мөнгийг авъя аа гэхээр өгөхгүй байна аа. Тэгэхээр энийгээ хэрэгжүүлж ажиллаарай л гэж та бүхэнд хэлээд байгаа юм. Энэ бол бодлого шүү.

Цаашдаа яах вэ гэхээр иргэн болгон маань ингээд өөрөө өөртөө эрчим хүчээ үйлдвэрлээд илүүгээ төвийн сүлжээн рүү өгөөд байхад яах вэ гэхээр Монгол Улс энэ эрчим хүчний салбар чинь өөрөө жинхэнэ утгаараа либералчлагдаж эхэлнэ. Дараа нь иргэн болгон өөрөө станцтай болчих юм бол би илүү хямдхан үнээр өгье өө гээд энэ зах зээлийнхээ зарчмаар өрсөлдөөнд ороод эхэлнэ. Тэгээд энийг чинь гол бодлого суурь нь л энэ дээр явж байгаа шүү дээ.

Түүнээс бол бид нар энэ чинь хаасан, боосон биш нээсэн, иргэддээ боломж олгосон шийдвэрүүдийг л Их Хурал, Засгийн газар гар.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Санал хэллээ. Нэг асуулт байгаа. Зээлийн хувьд бол маш сайн зээл гэж бодож байгаа. Тэгээд 2 хувийн хүүтэй гэдэг чинь энийг сая бас гишүүдийн асуултад гарсан уу тодорхой хэлээдхээч яг аль хотод ямар ямар зүйл зарцуулах вэ? Энийг ямар хуулиар хэдэн компани гүйцэтгэхээр худалдан авах ажиллагаа зарлах вэ? Энэ талаар.

Хоёрдугаарт нь бол энэ Монгол Улсын хүлээгдэж байгаа томоохон цахилгаан станцууд, Тавантолгойн цахилгаан станц ямархуу шатандаа явж байна? Энэ дээр товч хариулт өгөөч. Мөн Даланзадгадын 50мвт-ын цахилгаан станц ямар шатандаа явж байна?

Энэ дээр Эрчим хүчний яам тайлбар өгье. 4 номер.

**И.Лувсанцэрэн:** Энэ дэд станцын маань байршил энэ паркт хотын төвд байршиж байгаа. Нийслэлээс бол 0.12 га газрыг бол шийдэж өгсөн хотын төвд байрлана. Энэ дэд станц маань баригдсанаар бол Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Баянзүрх зэрэг 5 дүүргийн 14 хорооны бас энэ хотын төвийн 1 дүгээр зэргийн хэрэглэгчдийг, мөн 1, 2 дугаар эмнэлэг, Өргөө амаржих гэж газар зэрэг ийм нийтдээ 11-н 1 дүгээр зэргийн хэрэглэгчид болон 832 хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хангамж бол сайжрах юм байгаа юм.

Зээлийн хэлэлцээр батлагдаад ирэх нөхцөлд бол энэ олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг Германы Сэргээн босголт, хөгжлийн банкны журмын дагуу бол зохион байгуулагдаад явна.

Тавантолгойн дулааны цахилгаан станц маань төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх шийдвэр гарсан. Эдийн засаг, хөгжлийн яаманд эрчим хүчний зүгээс төслийн бэлтгэл ажилтай холбоотой материалуудыг хүргүүлсэн. Ингээд Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтраад ажиллаж байна. Удахгүй бас энэ төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд энэ төсөл маань цаашаагаа хэрэгжинэ ээ гэж ойлгож болно.

Даланзадгадын дулааны цахилгаан станцын хувьд гэх бол орон нутаг өөрөө бонд гаргаад бас хэрэгжүүлэхээр 5 сарын 1-нд гээд бонд гаргана аа гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Даланзадгадын дулааны цахилгаан станц дээр мөн бид бүхэн энэ төсөл дээр дэмжлэг үзүүлэх үүднээс Эрчим хүчний яамнаас бүрэн эрхт төлөөлөгчийг тавин бэлтгэл ажлыг бас хангаад явж байгаа.

**Р.Сэддорж:** Тавантооголгой станц хэзээ ашиглалтад орно гэнэ ээ, хэзээ эхэлнэ гэнэ ээ ажил нь?

**И.Лувсанцэрэн:** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд явахаар Засгийн газрын тогтоол шийдвэр гарсан. Бэлтгэл ажлууд бүгд хангагдсан. Үндсэндээ сонгон шалгаруулалт нь яваад гүйцэтгэгч гэрээ байгуулагдсан нөхцөлд 3.5 жил барилга угсралтын ажил явагдах 29-өөс 30 оны түвшинд бол ашиглалтад оруулна гэсэн ийм бэлтгэл ажилтай явж байгаа.

**Р.Сэддорж:** Тендер зарлахгүй гэсэн үг үү тээ? Хариулт 4 номер.

**И.Лувсанцэрэн:** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн дагуу явагдана.

**Р.Сэддорж:** Гишүүд асуулт хариулт, асуулт асууж дууслаа.

Хэлэлцээрийн төслийн талаар үг хэлэх гишүүд байна уу?

Булгантуяа гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд.

**Л.Соронзонболд:** Энэ зээлийн хүүгийн хүү нь бага байлаа гээд өртөг нь аягүй өндөр болж байгаа юм шиг надад санагдаад байгаа байхгүй юу. Энэ чинь 4км газар доогуурх цахилгаан дамжуулах шугам сүлжээ барихын тулд километр нь 9 тэрбум төгрөг тэгээд бараг 2.6, 7-н сая доллар зарцуулж байна шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт болохоор бол зөвлөх үйлчилгээ гээд 1 сая евро бараг авч байна. 2 дэд станц барихад 4 тэрбум төгрөг авч байна. Гэтэл өнөөдөр Монгол Улсын бусад төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа дэд станц дээр ажиллаж байгаа зөвлөх үйлчилгээний компаниуд энэ хэмжээний юм авч байгаа юу үгүй юу гээд. Ер нь яах вэ би зүгээр Найдалаа сайд ингээд шинээр Эрчим хүчний сайд болсон. Тийм учраас иймэрхүү бас энэ хэдийгээр санхүүгийн өртөг нь бага боловч нөгөө бодит үйл ажиллагаа явуулж байгаа өртөг нь өндөр болж байгаа иймэрхүү кэйсүүд бас танай яаман дээр нэлээн байж магадгүй юм шиг харагдаад байгаа. Хэд хэдэн удаагийн төслүүд орж ирсэн. Ер нь дандаа өндөр өртөгтэй орж ирж байгаа. Тийм учраас энэ тал дээр бас анхаарах анхаарч ажиллах ёстой гэж зориудаар тэмдэглэж хэлмээр байна.

**Р.Сэддорж:** Булгантуяа гишүүн.

**Х.Булгантуяа:** Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтыг их дэмжиж байна. Түрүүн тэгэхдээ Соронзонболд гишүүний хэлж байгаагаар олон улсын зээлийн хэлэлцээртэй холбоотой дагалдах зардлууд тэгээд олон улсын зээлээр ер нь хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд бол өртөг нь бол өндөр байдаг манай Сангийн яамны хөрөнгө оруулалтынхан бол сайн мэдэж байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаагаас бараг 2 дахин өндөр байдаг.

Тэгээд зарим бүр зээлийн хэлэлцээрүүд нь урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ, зураг төсөв бүгдээрэнг нь гаднын компаниудаар хийлгэх ёстой гээд нөгөөдүүл нь ахиад төсөвт өртгүүд нь маш их өндөр байдаг. Хүүгийн зардал нь бага байлаа гэхэд ер нь бол бас дүндээ дүн болчихоод байдаг юм. Одоо яах вэ бид нар улсын төсөв хүнд, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, шаардлага их байгаа учраас бид нар үүнийг өөрснөө одоохондоо бүрэн санхүүжүүлэх төсөв, санхүүгийн хувьд хүндрэлтэй учраас энэ бүгдийг хүлээн зөвшөөрөөд л нэг бодлын явж байгаа болчихоод байгаа юм. Тэрнээс биш яг ингээд төсөвт өртөг энэ бүгдийг харвал ер нь жоохон өндөр байгааг бол та бүхэн маань өөрснөө бүгдээрээ сайн мэдэж байгаа.

Зам тавих ч гэсэн мөн адилхан. Зам ч гэсэн яг адилхан. Улсын төсвийн хөрөнгө оруулалт бас бараг 2 дахин, зарим нь бараг 3 дахин өндөр байгаад байгаа. Тэгээд би зүгээр өмнө нь бас хэлж байсан энэ эдийн засгийн хувьд үр өгөөжтэй, дээрээс нь нэмээд өөрснөө эргэн төлөх боломжтой ийм төсөл, хөтөлбөрүүдийг бол ялангуяа эрчим хүчний салбаруудынхыг, дээрээс нь нэмээд өмнө нь Сангийн яаман дээр бид нар бас энэ эргэн төлөлтүүдийг аваад үзэж байхад жишээлбэл төмөр зам гэх мэтчилэн энэ зээлийн хэлэлцээрүүдийг бол эргэн төлөгдөхийг нь заавал өөрсдөд нь хариуцуулах нь зүйтэй юм. Татвар төлөгчдийн мөнгөөр үүнийг эргэн төлүүлэх биш, орлогоосоо өөрөө буцаад зээлээ буцаж төлөх ийм зээлийн хэлэлцээрүүдийг дамжуулан зээллэг байдлаар хийх нь зүйтэй.

Эрчим хүчний салбар өөрөө үүнийгээ өөрсдийнхөө төлөвлөгөөнд оруулаад хэдэн жилийн дараа бид нар эргэн төлөхийн тулд тариф ийм байх ёстой гээд санхүүгийн сахилга бат, санхүүгийн төлөвлөгөөгөө эртнээс гаргаад явах нь зүйтэй. Тэгж явж чадахгүйгээр яадаг вэ гэхээр яг цаг нь тулангуут бид нар энийг чинь төлж чадахгүй шүү дээ одоо, улсын төсвөөр татвар төлөгчдийн мөнгөөр үүнийгээ төл гэдэг ийм асуудал руу ордог. Тэгээд эсрэгээрээ энэ бол эдийн засгийн ийм хөрөнгө оруулалтуудыг бол эргэн төлөлтийг нь тухайн салбарт нь ТӨК-д нь хариуцуулаад ТӨК-удыг нь харин шахаад явах нь зүйтэй юм аа гэж бодож байна.

Магадгүй Эдийн засаг, хөгжлийн яаман дээр одоо зүгээр эргэн төлөлт нь нэлээн дөхчихсөн байгаа төсөл, хөтөлбөрүүдийг дор хаяж 5 жилийн дараагаар байдаг юм уу төлөгдөх иймд зээлийн хэлэлцээрүүдийг 1 удаа авч хэлэлцээд Сэдээ дарга аа тэгээд ер нь эргэн төлөгдөх боломж, бололцоо нь ямар байгаа вэ? Графикийн хувьд яаж харж байгаа вэ, ТӨК-уд орон нутаг өөрөө эргэн төлөхөөр хариуцаж авсан байгаа бол, дамжуулан зээлсэн байгаа бол тэрүүнийг төлөх боломжтой байгаа юу гэдэг талаар 1 удаа сонсвол бас их зүгээр байж магадгүй гэж бодож байна. Яагаад гэвэл яг тулчихаар орон нутгууд ч тэр ТӨК-уд ч гэсэн бид нар ерөөсөө тооцоолоогүй бид нар энийг эргэн төлж татахгүй гэдэг асуудлууд гардаг.

Миний санаж байгаагаар зарим орон нутаг дамжуулан зээлээд дараа нь бүүр юу гэж хэлж байсан бэ гэхээр үгүй ээ энэ нөгөө намын авсан зээллэг байна шүү дээ бид нар яахаараа төлөх ёстой юм бэ гэдэг асуудлыг хүртэл ярьдаг. Тэгээд энэ бол нэгэнт Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын төр засаг авчихсан зээл учраас хэний нам тэр тухайн үед эрх барьж байсан нь үл хамааран төлөх нь үнэн юм чинь эртнээс үүн дээр Улсын Их Хурал хяналт тавьж шаардлагатай бол үүрэг даалгавар өгч байх нь зүйтэй юм болов уу гэж бодож байна. Тэгээд Сэддорж дарга үүнийг Эдийн засгийн байнгын хороон дээр удаа авч хэлэлцээсэй гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Булгантуяа гишүүний хэлсэн маш зүйтэй санал байна. Тэгээд яг одоо Байнгын хорооны ажлын албанд Эдийн засгийн байнгын хорооноос энэ саяын Булгантуяа гишүүний хэлсэн зүйлтэй холбоотой хэлэлцүүлэг юм уу мэдээлэл авъя. Энэ бол Монгол Улсын бүх татвар төлөгчид энийг төлдөг. Маш нухацтай хандах ёстой. Өнгөрсөн үеийн авсан зүйлүүд дээр маш нухацтай дүгнэлт хийх ёстой. Тийм учраас ахлах энэ асуудлыг зохион байгуулаарай.

Миний хэлэх үг бол энэ Соронзонболд гишүүнтэй их ойролцоо байна л даа. 17 сая еврогийн 1 сая евро нь зөвлөх үйлчилгээ юм байна тээ? Энэ яахаараа ийм үнэтэй байдаг юм? Мөн гадаадын зээлд заавал дагалдаж ирдэг менежментийн зардал, зөвлөх үйлчилгээ гэж 2 юм байгаа. Энэ заавал байх ёстой юу? Заавал ийм өндөр үнэтэй байх ёстой юу? 17-ны 1 нь байна шүү дээ энэ зээлийн энэ дээр та та бүхэн энэ үг явж байгаа учраас та бүхэн цаасаар уулзаж энийг тайлбарлаач ээ. Бас гишүүд ч бас энийг бас мэдэхийг хүсэж байгаа. Тийм учраас холбогдох хоёр яам хоёулаа энэ дээр тайлбар өгөөч.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье.

Саналын томъёолол Монгол Улс Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулах “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн болон төслийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Саналын томъёолол Монгол Улс Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банк хооронд байгуулах “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн III үе шат”-ны зээлийн

болон төслийн хэлэлцээрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Анар гишүүн, Батсүмбэрэл гишүүн, Жаргалан гишүүн, Очирбат гишүүн. Очирбат гишүүн, Жаргалан гишүүн хоёр? Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Очирбат танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

11.27 цаг

## **Хэлэлцэх асуудал 2.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.**

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

**Б.Заяабал:** Эдийн засгийн байнгын хорооны дарга гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг хууль санаачлагчийн зүгээс боловсруулан та бүхэнд бас танилцуулж байна. Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөл маань 13 бүлэг 93 зүйлтэй бөгөөд энэхүү төсөлтэй хамт Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Санхүүгийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан байгаа.

Уг хуулийн төслийг Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Дундговь, Дорноговь, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршоод болон иргэдийг оролцуулсан ийм хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Мөн түүнчлэн 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөс хойш бас D-Parliament.mn дээр цахим хуудсаар иргэдэд нээлттэй тавьж бас олон нийтээр хэлэлцүүлж ирүүлсэн саналуудыг судалж бас хуулийн төсөлд тусгасан гэдгийгээ бас илэрхийлье.

Уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хууль, эрх зүйн төрийн бодлогын урт, дунд хугацааны бодлоготой уялдсан талаарх бас тодорхой мэдээллүүдийг бас өгье.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын 4 дүгээр бүлгийн 4.3 дахь зорилтод олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлэн хөгжүүлнэ гэж тусгасан. Мөн Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3.1-д сан, санхүү, даатгалын хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ. 3.1.3.2-т бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд таатай нөхцөлөөр санал болгох санхүүгийн бүтээгдэхүүнийг дэмжинэ гэж тус тус

заасан. Эдгээр хууль урт хугацааны болон дунд хугацааны хууль төрийн бодлого дээр нийцүүлэн бас эдгээр хуулийг боловсруулсан гэдгийг хэлье.

Өнөөдөр Монгол Улсад энэ санхүүгийн хоршоо буюу өмнө нь бид нарын хэлж заншсан хадгаламж, зээлийн хоршоодын ер нь түүх нь ямар юм бэ гэдэгтэй холбоотой бас тодорхой мэдээллүүдийг бас өгье гэж ингэж бодож байна.

Монгол Улсад хадгаламж, зээлийн хоршоод 1996 оноос эхлэн байгуулагдаж түүхийн тодорхой үе шатыг давж өнөөдрийг хүрсэн байдаг. Хадгаламж, зээлийн хоршооны 2005-2006 оны хямрал, хяналт, зохицуулалт хангалтгүй, иргэдийн хоршооны тухай мэдлэг муу байснаас зарим хоршоодын үйл ажиллагаа ашгийн бус байх, нийгмийн чиг баримжаатай байх сонгодог утгаасаа гажуудаж, банк хөрөнгө оруулалтын сангийн шинжтэйгээр үйл ажиллагааг хэрэгжүүлж, анх үүсгэн байгуулсан бүлэг этгээдүүдэд хоршооны удирдлага төвлөрсөнтэй холбоотойгоор хоршооны гишүүд хадгаламж эзэмшигчдийн эрх ашиг бол хохирч ирсэн. Энэ үйл явдал дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн хоршооллын хөдөлгөөний нэр хүндийг Монгол Улсад унагасан ийм хор уршгийг бол авчирсан байдаг.

Үүссэн нөхцөл байдлыг засаж салбарыг хянах, зохицуулах байгууллагыг бий болгож анх удаагаа Монгол Улсын Их Хурлаас 2011 онд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталж, салбарыг цэгцлэх үйл ажиллагаа бол явагдаж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 172 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаагаа явуулж байгаагаас 53.5 хувь буюу 92 хадгаламж, зээлийн хоршоо орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. 46.5 хувь буюу 80 хадгаламж, зээлийн хоршоо Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

2025 оны байдлаар салбарын нийт хөрөнгө 379 тэрбум төгрөгт хүрч, ДНБ-ий 0.5 хувь, гол үзүүлэлт болох хадгаламж болон зээлийн дүн, банкны зах зээлийн мөн үзүүлэлтийн 0.5 хувьтай тэнцэж байна. 1 зээлдэгчид ноогдох дундаж зээл 10.3 сая төгрөг бөгөөд тус үзүүлэлт нь Улаанбаатар хотод 17.4 сая төгрөг, орон нутагт 4.9 сая төгрөг байна. 1 хадгаламж эзэмшигчид ноогдох дундаж хадгаламж 5.3 сая төгрөг бөгөөд тус үзүүлэлт нь Улаанбаатар хотод 7.5 сая төгрөг, орон нутагт 2.9 сая төгрөг байна. Нийт гишүүдийн тоо 2025 оны байдлаар 77155 иргэнд хүрсэн нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 5.5 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлтээрээ бол Азийн дундаж үзүүлэлт болох 6.6 хувьтай бол ойролцоо. Дэлхийн дундаж үзүүлэлт болох 11.2 хувь байгаа дэлхийн дундаж үзүүлэлт эндээс бол 5.7 функтээр доогуур байна аа гэсэн ийм үзүүлэлт гарч ирж байгаа.

Монгол Улсын 18-64 насны эдийн засгийн идэвхтэй хүн амын 26 хүн тутмынх нь 1 нь хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байна. 71 хүн тутмынх нь зээл авсан байна. 41 хүн тутмынх нь хадгаламж төвлөрүүлсэн байна гэсэн ийм статистик мэдээлэл байгаа.

Хэдийгээр санхүүгийн зах зээлд эзлэх хэмжээ харьцангуй бага ч тогтвортой, зохистой өсөлтийг үзүүлж буй бас ийм зах зээл болж төлөвшиж байгаа. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2015 онд Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотой, 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулсан нэмэлт өөрчлөлттэй холбоотой, мөн түүнчлэн 2023 оны Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой, 2024 онд Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой хуулийн хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 4 удаа бас тус хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулснаас өөрөөр шинэчлэл хийгдээгүй байгаа.

Тасралтгүй хөгжиж байгаа энэ зах зээлийн энэ чиг баримжаатай чиг хандлагад тохирсон зохицуулалтыг бий болгоход хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох, гишүүдийн санхүүгийн хэрэгцээнээс гадна нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг бүрэн хангаж чадахуйц хоршоодыг хөгжүүлж, олон улсын чиг хандлагад нийцүүлэх ийм шаардлага бол тулгарч байгаа.

Олон улсын туршлагаас бас судалж үзэхэд хадгаламж, зээлийн хоршоодын талаар тогтсон нэршил бас олон улсад тодорхой биш байна. Тухайлбал, олон улсад бид бүхний мэдэж байгаа Зээлийн холбоо буюу “Кредит Юнион” хоршооллын банк буюу энэ “cooperative Bank”, хамтын банк буюу ... bank, хөршийн банк буюу “Neighbor bank”, хадгаламж, зээлийн хоршоо буюу “Saving&Credit Cooperatives” гэсэн янз янзын нэр томъёотойгоор ашиглагдаж, хэрэглэгдэж явж байгаа боловч Дэлхийн банк эдгээр нэршлийг нэгтгэсэн байдлаар бол санхүүгийн хоршоо буюу “Financial cooperative” гэсэн нэр томъёолол бол Сүүлийн үед бол нэлээн хэрэглэж байгаа.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн нэрийг Санхүүгийн хоршооны тухай хууль болгон өөрчилж салбарын нэршлийг өөрчлөх алхам нь гишүүдийн хэрэгцээнд нийцсэн олон төрлийн санхүүгийн үйлчилгээг хүргэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ийм зохицуулалтын орчныг бий болгосноор гадаадын зорилтод болон хөнгөлөлттэй төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх, санхүүжилт авах боломжуудыг бүрдэх зэрэгтэй шууд уялдуулахаас гадна олон нийтийн дундах хоршооны талаарх сөрөг төсөөллийг бууруулж, салбарын хөгжлийг эрчимжүүлэх зорилготой ийм дахин rebranding хийх үүднээс энд санхүүгийн хоршоо гэсэн ийм шинэ нэршлийг бас олон улсын жишигт нийцүүлэн оруулж ирж байгаа гэдгийг бас та бүхэнд хэлье.

Иргэд хоорондын харилцан туслалцах зарчим дээр тулгуурлан байгуулагдаж, санхүүгийн үйлчилгээг зөвхөн гишүүддээ хүргэж ашигладаг учраас санхүүгийн хоршооны салбар улс орны санхүүгийн системд онцгой байрыг эзэлдэг учраас төрийн бодлогоор бол дэмждэг. Тухайлбал, зах зээлийн найдвартай байдал болон хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд дэлхийн улс орнууд хамгаалалтын 2-3 давхарга бүхий тогтолцоог бий болгож ирсэн.

Тодруулбал нэгдүгээрт, санхүүгийн хоршоодын цэвэр орлогоос байгуулдаг нөөцийн сан, хоёрдугаарт үйл ажиллагааны түр хугацааны хүндрэлд орсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан санхүүгийн хоршоодыг хоршоодод мэргэжил арга зүйн дэмжлэг, санхүүгийн туслалцаа үзүүлэх, дампуурлаас сэргийлэх үйл ажиллагааг чиглэсэн тогтворжуулалтын сан, гуравдугаарт нь хадгаламжийн даатгал бөгөөд хоршоо дампуурсан тохиолдолд даатгагдсан хадгаламжийг хадгаламж эзэмшигчдэд нөхөн олгодог ийм 3 ийм хамгаалалтын системийг бас оруулж ирж өгсөн байгаа. Олон улсын чиг хандлагад уг хадгаламж хамгаалалттай холбоотой асуудалд санхүүгийн хоршоодыг банкны салбарын нэгэн адил зохицуулахад чиглэсэн байдаг.

Хадгаламж хамгаалах тогтолцоог нэвтрүүлснээр зах зээлд орох мөнгөний урсгал нэмэгдэх, гишүүдийн тоо өсөх, иргэдийн санхүүгийн хоршоод цаашлаад санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж ингэж үзэж байгаа.

Манай орны хувьд бол санхүүгийн хоршоод хамгаалалтын нэг дүгээр давхарга буюу энэ нөөцийн сангийн хүрээ.../минут дуусав./

**Л.Соронзонболд:** Заяавал гишүүний микрофоныг гүйцээж өгье.

**Б.Заяабал:** Манай орны хувьд бол нэгдүгээр давхарга буюу нөөцийн сангийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Харин хамгаалалтын олон давхаргад тогтолцоог үе шаттай нэвтрүүлснээр салбарын нэгдсэн бодлого, удирдлагын доор төрд үүсэх дарамтгүйгээр салбарыг тогтвортой хөгжүүлж, гишүүдийн эрх ашгийг хамгаалах замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой гэж ингэж харж байгаа.

Хадгаламж, зээлийн хоршоодын тухай хуулийг шинэчлэн найруулж Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг баталснаар дараах үр дүнд хүрнэ гэж хууль санаачлагчийн зүгээс бол үзэж байгаа.

Нэгдүгээрт нь санхүүгийн хоршооны салбарын нэгдсэн дэд бүтэц буюу тогтворжуулалтын сан, хадгаламжийн даатгал зэрэг хамгаалалтын олон давхарга тогтолцоог олон улсын түвшинд нийцсэн байдлаар үе шаттай нэвтрүүлснээр салбарын нэгдсэн бодлого, удирдлагын доор төрд үүсэх дарамтгүйгээр санхүүгийн хоршооны үйл ажиллагаа тогтвортой хөгжих боломж үүснэ гэж ингэж үзэж байна.

Хоёрдугаарт, санхүүгийн хоршооны засаглал, санхүүгийн тайлагнал, технологийн дэвшил, цахим шилжилттэй холбоотой өөрчлөлтүүдийг тусгаж, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтуудыг хийгдсэнээр санхүүгийн хоршооны зах зээлийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн цаашдын өсөлтийн нөхцөлийг бүрдүүлэх, гишүүн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах механизм боловсронгуй болно оо гэж ингэж харж байгаа.

Гуравдугаарт нь санхүүгийн хоршоогоор дамжуулан иргэдэд санхүүгийн боловсрол олгож зөв дадал хэвшил суулгаснаар төв газраас алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, гишүүдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн хүн төвтэй хоршоодыг хөгжүүлж, сүүдрийн эдийн засаг, мөнгө хүүлэгчтэй бол тэмцэх ийм нөхцөл бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Дөрөвдүгээрт, санхүүгийн хоршооноос үйлчилгээ авах шаардлагатай, боломжтой бүхий л хүнд хүрч үйлчлэхийг зорьдог. Гишүүддээ ойр байгуулах тул хоршооноос үүссэн ашиг, тухайн орон нутагт гишүүддээ үлдэж, орон нутгийг хөгжүүлэхэд бас нэмэр нөлөө үзүүлнэ гэж ингэж харж байгаа.

Тавдугаарт нь санхүүгийн хоршоо нь гишүүдийн хэрэгцээг хангах зорилгоор бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ, орон нутгийн хөгжил, ногоон санхүүг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, байгаль орчныг хамгаалах үйлсэд бас хувь нэмрээ оруулна гэж ингэж харж байгаа.

Зургаад нь хууль батлагдсанаар санхүүгийн хоршооны үйл ажиллагаанд тавьж буй хянан шалгалтын үр нөлөө, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, зохицуулалтын эрх зүйн орчин нь олон улсын жишигт нийцэж, санхүүгийн салбарт бий болж болзошгүй эрсдэлээс урьдчилан тооцоолж, түүнээс сэргийлэх, ингэснээрээ санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, салбарын хөгжлийг дэмжих таатай орчин бий болно гэж ингэж үзэж байна.

Мөн санхүүгийн хоршооны үйл ажиллагааны цар хүрээ өргөжих, санхүүгийн шинэ үйлчилгээ бий болох, санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, гишүүн төвтэй зохицуулалтын орчин бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

Мөн түүнчлэн санхүүгийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, салбарын цаашдын хөгжлийг дэмжсэн чухал арга хэмжээ болно гэж ингэж бидний зүгээс үзэж байгаа гэдгийг та бүхэндээ дуулгая.

Ингээд Байнгын хорооны гишүүд та бүхэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Л.Соронзонболд:** Ажлын хэсгийг танилцуулъя. Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Долгорсүрэн Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга, Алтантуул Санхүүгийн зохицуулах хорооны Хадгаламж, зээлийн хоршооны газрын дарга, Мөнх-Оргил Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Соёлмаа Санхүүгийн зохицуулах хорооны хадгаламж, зээлийн хоршооны газрын ахлах зөвлөх, Ариунболд Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирал, Амарбилэг Хадгаламжийн даатгалын корпорацын Даатгалын хураамж, хяналт шалгалтын эрсдэлийн удирдлагын газрын захирал, Хулан Хадгаламжийн даатгалын корпорацын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Пунсалмаа гишүүнээр тасалъя. Жаргалан гишүүнээр тасалъя. Хэн бэ? Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Одоо манайд яах вэ энэ бол санхүүгийн хоршоо. Гэхдээ хоршоо гэдэг ерөнхий бүтэц, зохион байгуулалт Шинэ хоршоо гээд том хөдөлгөөн 5 жилийн хугацаатай хэрэгжээд ер нь явж байгаа. Тэгэхээр энэ хоршооны, харамсалтай нь энэ хоршоо бол ингээд 1 жилийн хугацаа дөнгөж өнгөрсөн үү үгүй юу үр дүнгийн асуудлыг гишүүд маань бас ярьж эхэлж байгаа.

Тэгэхээр яг энэнтэй адилхан санхүүгийн хоршоог энэ хууль хэрэгжээд 5 жилийн хугацаанд ер нь яг энэ эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад олгож байгаа энэ зээл, шинээр бий болж байгаа хоршооны тоо яг хэд болно гэж ер нь харж байгаа вэ? Хэдэн төрлийн бүтээгдэхүүнүүд энэ санхүүгийн хоршоогоор бий болох юм, хүлээгдэж байгаа ер нь яг ямар үр дүн бид нар эндээс ялангуяа эдийн засгийн яг энэ гол салбаруудад ямар импакт үзүүлнэ гэж энэ санхүүгийн хоршоогоор дамжуулаад бий болно гэж харж байгаа вэ гэдэг асуулт байна.

Хоёрдугаарт, энэ танилцуулга дээр байсан Канадад хөдөлмөр эрхэлж байгаа 2 хүний 1 нь хоршооны гишүүн, Солонгост 4 хүний 1, гэтэл Монголд 100 хүний 2 нь бол хоршооны гишүүн байна. Тэгэхлээр одоо ингээд энэ санхүүгийн хоршоо хөгжөөд явах юм бол банк болон банк бусын үйл ажиллагаатай бас өрсөлдөхүйц хэмжээнд хүрэх ийм ирээдүйн зорилт байгаа болов уу? Тэгвэл энэ банк болон банк бустай өрсөлдөх энэ зохистой харьцааг хэд гэж харж байгаа, энийг хадгалж чадах уу гэдэг асуулт байгаад байгаа юм.

Гуравдугаарт, энэ хоршоологчдын татварыг хөнгөлөх, чөлөөлөх ийм талын заалтыг бол энэ хууль дээр тусгажээ. Хуулийн үзэл баримтлал дээр энэ зээлийн хүүг хэдий хугацаанд хэдэн хувиар бууруулах тооцоо, судалгаа байгаа вэ гэдгийг бас асуумаар байна. Одоо энэ зээлийн хүүг бууруулах гэдэг асуудлыг ярьж байгаа боловч бас л аягүй их асуудал дагуулсан. Тэгэхээр энэ хууль дээр ингээд шууд зээлийн хүүг бууруулна гэдгийг яг ямар үндэслэлээр энэ зээлийн хүүг бууруулна гэж ерөнхийдөө харж байгаа юм.

Мөн мөнгө хүүлэгчтэй тэмцэхэд тусална аа гээд оруулчихсан байгаад байгаа энэ хууль дээр. Мөнгө хүүлэгчдийг хэмжиж яг үзсэн юм уу? Энэ хэр том түвшинд энэ мөнгө хүүлэгчийн асуудал ер нь байгаа юм? Энэтэй холбоотой тооцоо ер нь байгаа юу? Зээлдэгчдийн хэдэн төгрөгийг мөнгө хүүлэгч дээр дамжиж алдсан байгаа юм өнөөдрийн байдлаар? Хэдэн төгрөгийн хохирол хэдэн иргэдийн асуудлыг бид нар ярьж байгаа юм? Тэгээд яаж энэ мөнгө хүүлэгчтэй тэмцэх асуудлыг ер нь буурна гэж харж байгаа юм бэ гэдэг тодорхой хариулт өгөөч.

Тэгээд хэрэв хоршоо дампуурах юм бол нөхөн төлбөрийг олгоно оо гээд заачихсан байгаад байгаа юм даатгалаар дамжуулаад. Тэгтэл энэ дээр даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн даатгалын корпорацын санхүүгийн хоршоо хадгаламж эзэмшигчийн 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхнө өө гээд 20 саяар хязгаарлачихсан байгаад байгаа юм. Энэ ер нь яг ямар үндэслэлтэй тооцоо вэ, яагаад 20 сая гэдгээр хязгаарласан байгаа юм бэ гэдгийг асуултуудыг эхлээд асуучхаад байна.

**Л.Соронзонболд:** Хууль санаачлагч Үүрийнтуяа гишүүний микрофоныг нээе.

**Д.Үүрийнтуяа:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт хөдөө аж ахуйн хоршоо үүссэн нөхцөл байдал бол бас арай өөр нөхцөлд үүссэн л дээ. Хадгаламж, зээлийн хоршоо бол орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа энэ хадгаламж, зээлийн хоршоодын дийлэнх нь малчид байдаг. Малчид маань бас 2023-аас 24 оны энэ өвлийн зуднаар хүнд нөхцөл байдалд орж, энэ нөхцөл байдалд бол тухайн үеийн Засгийн газраас бас арга хэмжээ авч, малчдын энэ хүндэрсэн нөхцөлийг засаж залруулах, хөдөлмөрөөрөө нэгдэх, энэ боломжийг нь хөдөө аж ахуйн хоршоогоор олгоё оо гэж хандаж хөнгөлөлттэй зээл олгох энэ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ үндсэн дээр бол санхүүгийн хоршоод нэгдэж хөдөө аж ахуйн хоршоо үүссэн. Шинээр ч хөдөө аж ахуйн хоршоод байгуулагдсан. Энэ үед бол хадгаламж, зээлийн хоршоод орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулж энэ хөдөө аж ахуйн хоршоодод олгож байгаа зээлийг олгох боломжтой эсэх талаар Санхүүгийн зохицуулах хорооноос тухайн үед Амарбаясгалан даргад хандаж албан бичиг хүргүүлсэн байдаг юм.

Тэгээд тэр үед бол энэ бол зөвхөн хөдөө аж ахуйн хоршоодыг дэмжих, хөдөө аж ахуйн чиглэлээр хөдөлмөрөөрөө хоршиж байгаа хоршоодыг дэмжих ийм зээл учраас санхүүгийн хоршоод буюу хадгаламж, зээлийн хоршоод бол хамаарахгүй ээ гэсэн ийм хариултыг өгсөн байдаг.

Тэгэхээр хөдөө аж ахуйн хоршоод өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн дэмжлэг аваад шинээр байгуулагдаад явж байгаа энэ хөдөө аж ахуйн хоршоод бол санхүүгийн хоршоод той өнөөдрийн байдлаар ямар нэгэн байдлаар уялдаагүй, санхүүгийн хоршоодын хувьд ямар нэгэн байдлаар хөдөө аж ахуйн

хоршоодод олгож байгаа зээл, хөнгөлөлтөд хамрагдсан юм бол байхгүй. Тус тусдаа үйл ажиллагаа эрхэлж байна аа гэж ойлгож болно.

Монгол Улсад энэ хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагдсан энэ цаг хугацаанаас хойш бид бол хоршоо гэдэг нэг ойлголттой явсаар ирсэн. Хоршоо гэдэг нэг ойлголттой, энэ хоршоо гэдэг Хоршооны хуулиар бүгдийг зохицуулдаг байж байгаад 96 оноос эхлээд хадгаламж зээлийн Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдаж хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаа маань 2004, 2005 онд бол нэлээн хямралт хууль, эрх зүйн зохицуулалтгүйгээсээ болж бас томоохон хямралд орсныг та бүхэн мэдэж байгаа.

Ийм учраас энэ 2011 онд хадгаламж, зээлийн хоршооны хуулийг анх боловсруулсан байдаг юм санаачилга. Тэгээд энэ хууль нь өнөөдрийг хүртэл энэ цаг хугацаанд 15 жилийн хугацаанд үндсэндээ 4 хуулийг дагаж л нэмэлт, өөрчлөлт орсон уу гэхээс эрх зүйн зохицуулалтын хувьд ямар ч өөрчлөлт хийгдээгүй өнөөдрийг хүрсэн байна.

Тэгэхээр зах зээлийн нөхцөл байдал, олон улсын жишиг хандлагатайгаа уялдуулаад санхүүгийн зах зээлийн хамгийн бичил нэгж болж байгаа энэ хадгаламж, зээлийн хоршоодын эрх зүйн асуудлыг өнөөдөр зайлшгүй олон улсын түвшинд хүргэж, шинэчлэх шаардлага үүсжээ гэдэг нь харагдаж байгаа юм.

Тухайн үед үүссэн хохирлоос өнөөдрийг хүртэл 26.5 тэрбум төгрөг нөхөн төлөгдөөгүй явж л байгаа. Үүнээс хойш ингээд бидний хууль яг энэ зах зээл дээр хэрэгцээгээ хангаад явчав уу гээд ингээд аваад үзэхээр 1996 э онд байгуулагдсан хадгаламж, зээлийн хоршоо ер нь зээлийн хоршоо 2018 он гэхэд бас мөн ялгаагүй хэрэглэгчдийг хохироосон энэ хадгаламж эзэмшигчдийн хоршоодынхоо гишүүдийг хохироосон ийм асуудал үүссэн. Тийм учраас зайлшгүй бид энд бол өөрчлөлт хийх ёстой юм байна аа гэж үзэж байгаа юм.

Одоо Монголд 100 хүн тутмын 2 нь хоршооны гишүүн гэж байна таны хэлж байгаагаар. Бидний яг энэ санхүүгийн хоршоотой холбоотой хийсэн судалгаагаар 26-70 насны хүмүүс дунд яг энэ хадгаламж, зээлийн хоршоонд хамрагдаж байгаа гишүүдийн тоо, зээл авч байгаа хүний тоог үзэхээр 26 байгаа юм. Зээл авч байгаа нь 70 хүн байгаа юм 100 тутамд.

Тэгэхээр энэ бол юуг илэрхийлж байна гэхээр яг санхүүгийн бичил нэгжтэй хэдийгээр нийт банк, банк бус санхүүгийн байгууллага энэ зах зээл дээр эргэлдэж байгаа, санхүүгийн зах зээл дээр эргэлдэж байгаа зээл, хадгаламж энэ санхүүгийн үйлчилгээнийхээ дунд хадгаламж, зээлийн хоршоо бага дүн эзэлж байгаа боловч яг иргэдэд тулж очиж байна аа гэдгийг нь харуулж байгаа юм. Яагаад энэ санхүүгийн.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн гүйцээж хариулья.

**Д.Үүрийнтуяа:** Яагаад энэ мөнгө хүүлэгчидтэй тэмцэх, мөнгө хүүлэгчдийн эсрэг ажиллах боломжийг бүрдүүлнэ ээ гэж үзсэн юм бэ гэхээр өнөөдөр бол яг бодит нөхцөл байдал дээр банк, арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагад ч тэр, хадгаламж, зээлийн хоршоодод зээл олгодог тэрийг нь цааш нь аваад ард иргэдэд нэмээд нэмээд зээл олгодог хадгаламж, зээлийн хоршоонд, банк бус санхүүгийн байгууллага гишүүнчлэлээр ч байж байх жишээтэй. Өөрөөр

хэлбэл, хамгийн хямд эх үүсвэртэй зээлийг энэ санхүүгийн байгууллагууд нь өөрсдөө авангуутаа ард иргэдэд хамгийн өндөр хүүтэйгээр олгогдож байгаа юм.

Тийм учраас ард иргэдийг энэ зээлийн хүүгийн дарамтаас чөлөөлөхийн тулд яг энэ хадгаламж, зээлийн хоршоодыг мөнгө хүүлдэг хэлбэрээр биш гишүүддээ үйлчилдэг байдлаар явуулахыг хүсэж байгаа юм.

Өнөөдөр хэд хэдэн томоохон хоршоодыг бас бид судалсан. Яг энэ нөхцөл байдал дээр ерөөсөө өөрийн гишүүн болгож байгаа яаж гишүүнчлэлийг бий болгож байна гэхээр зээл өгөхийн тулд гишүүн болгодог, зээл олгодог, өндөр хүүтэй зээл олгодог. Яг тэр гишүүнчлэлийнхээ гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Мандхай гишүүн тодруулж асууна.

**М.Мандхай:** Санхүүгийн хоршоог ер нь бол дэмжиж байгаа. Гэхдээ хөдөө аж ахуйн хоршоо, даатгалын хоршоо, газар тариалангийн хоршоо гээд хоршооны өөрийнх нь ерөнхий бүтэц, зохион байгуулалт, үндсэн зорилго бол ер нь ижил юм. Хоршооны гишүүддээ үйлчилсэн л ийм бүтэц байхгүй юу.

Тэгэхлээр асуугаад байгаа миний яг тодорхой асуултад ерөөсөө хариулахгүй байгаад байна. 5 жилийн хугацаанд эдийн засгийн яг энэ ямар салбаруудад ямар импакт үзүүлнэ гэж харж байгаа юм бэ? Энэ олгосон зээл шинээр бий болгох гэж байгаа хоршооны тоо ер нь цаашдаа хэд болох юм? Хэдэн төрлийн бүтээгдэхүүнүүд бий болох юм? Одоо яг ярьж байгаа бол асуудал дээр ерөөсөө хуучин хадгаламж, зээлийн хоршооноос илүү гарах юм ерөөсөө хариулт би сонсож чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Яг давуу тал нь юу байх юм, дээрээс нь бас юм хэлэхэд энэ уг нь бол шинэ хоршоотойгоо уялдуулах ёстой гэж би бол харж байгаа юм. Яагаад гэхлээр нэгэнт хоршоо гэдэг зүйл бий.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Хууль санаачлагч Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Тэгэхээр 1 зүйлийг тодорхой бас ойлголт өгөх хэрэгтэй юм байна. Санхүүгийн хоршоодод төрөөс ямар нэгэн зээл олгохгүй. Төрөөс зээлийн хүү тогтоохгүй. Энэ хуулийн оруулж байгаа гол үзэл санаа юугаараа ялгаатай вэ гэхээр өнөөдөр хадгаламж, зээлийн хоршоо бол зээл олгодог, хадгаламж авдаг. Тэгвэл шинэ хуулиараа дахиад 3 үйлчилгээ нэмэгдэж байгаа. Даатгалын зуучлагчийн үйлчилгээ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ, факторингийн үйлчилгээ үзүүлэх боломжийг санхүүгийн хоршоодод олгож өгч байгаа юм. Таны хэлж байгаа зөв л дөө бид нар энэ хөдөө аж ахуйн хоршоодоо санхүүгийн хоршоодтойгоо уялдуулах механизмыг бас их эрэлхийлсэн. Өнөөдөр хөдөө аж ахуйн 2 хоршоо нийлээд санхүүгийн 1 хоршоо олох боломжтой байгаа юм. Орон нутагт бол хөдөө аж ахуйн хоршоод хоршоодын гишүүд хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байж л байгаа.

Тэгэхээр энийг уялдуулах боломж нь дахиад төрөөс энийг ямар нэгэн байдлаар санхүүжилтийг хөдөө аж ахуйн хоршоодыг дэмжиж санхүүжилт олгодог олгодог биш санхүүгийн эх үүсвэр нь санхүүгийн хоршоогоороо дамжиж, гишүүд нь өөрсдөө санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлж хөдөө аж ахуйн үйл ажиллагаа хөдөлмөрөөрөө хорших боломжийг нь нэгтгэдэг энэ боломжийг нь нээж өгөх.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Хариулт хангалтгүй гэж Мандхай гишүүн нэмж тодруулъя.

**М.Мандхай:** Яах вэ төрөөс санхүүжилт авахгүй ч гэсэн хэрэв хадгаламж, зээлийн хоршоо алдагдалтай, дампуурах түвшинд очих юм бол эргээд төр дээр эрсдэл үүсэх эрсдэлтэй учраас бид нар анхнаасаа энийг маш сайн энэ хуулийг цаашаа үргэлжлүүлэх үү, үгүй юү гэдэг дээр нягталж үзэх шаардлагатай байгаа юм.

Тэгэхлээр яг энэ хоршооны хууль хэрэгжсэнээр яг бодитой яг ямар үр дүн тухайн эдийн засгийн салбарт гарах вэ гээд болохгүй бол мэргэжлийн хүмүүс нь бас хариулаад өгөөч ээ гэж хэлмээр байна. Тэгээд энэ танилцуулга дээр би байгаа юмнуудыг л асуугаад байгаа шүү. Өнөөдөр Монголд 2 хувь байгаа гэдэг нь энэ танилцуулга дээр байсан. 100 хүний 2 нь хоршооны гишүүн байгааг нэмэгдүүлэх юм байна. Дээрээс нь энэ нийгэм эдийн засагт эерэг үр дагавар гаргах гэж байгаа юм бол яг ямар төрлийн эерэг үр дагавар гаргах гэж байгаа юм, энэ хууль хэрэгжсэнээр гэдэг ийм тоотой, үндэслэлтэй яг би үр дүн асуугаад байгаа байхгүй юу KPI. Энэ хууль хэрэгжээд явснаар санхүүгийн хоршоо байгуулсан гишүүдэд.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Ажлын хэсгээс сонсьё. 6 номер.

**Т.Жамбаажамц:** Мандхай гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Монгол Улсад өнөөдөр 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар нийтдээ 51.8 их наяд төгрөгийн зээл байгаа юм. Үүнээс арилжааны банканд 43.4 их наяд буюу нийт зээлийн 80.9 хувь. Банк санхүүгийн салбарт 7.2 хувь буюу 2 их наяд төгрөг буюу 13.9 хувь нь байгаа юм. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдүүдэд бол нийтдээ 840 тэрбум төгрөг буюу 1.6 хувь байгаа юм.

Гэтэл хадгаламж, зээлийн хоршоонд нийт зээлийн 290 тэрбум буюу 0.6 хувийг л эзэлж байгаа юм. Энэ эсрэгээр нь энэ зээлийн чанарыг аваад үзэхээр банкны 2025 оны жилийн эцсийн байдлаар банкны зээлийн чанаргүй зээлийн хэмжээ бол 5 аравны.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя.

**Т.Жамбаажамц:** Банк бус санхүүгийн салбарын чанаргүй зээлийн хэмжээ оны эцсийн байдлаар 8.4 хувь, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийн чанаргүй зээлийн хэмжээ 12.9 хувь байгаа бол хадгаламж, зээлийн хоршооны чанаргүй зээлийн хэмжээ 3 хувьтай байгаа юм. 3 хувьтай байгаа юм.

Гэтэл эндээс энэ тооноос юу харагдаж байна вэ гэхээр зээлийн хэмжээ бол асар бага байгаа 77 орчим мянган гишүүдэд зээлийн хэмжээ бол асар бага. Гэтэл нөгөө талдаа зээлийн чанар маш сайн байдаг. Ийм бичил санхүүгийн институт. Ялангуяа бол энэ хоршоо бол бусад санхүүгийн институцүүдээс юугаараа ялгаатай вэ гэхээр зөвхөн гишүүддээ үйлчилдэг ашгийн төлөө биш хамтын удирдлагатай ийм санхүүгийн институт.

Тийм учраас бид нар өнөөдөр бол энэ орон нутагт ялангуяа үйл үйлчилгээ, санхүүгийн үйлчилгээний хүртээмж бол одоогийн өнөөдрийн нөхцөл байдлаасаа бол 2-3 дахин, ойрын 3-5 жилийн хугацаанд өснө гэж харж байгаа.

Нөгөө талдаа энэ хэмжээгээрээ санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ ээ гэж.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн нэмж хариулъя.

**Д.Үүрийнтуяа:** Нөгөө найдваргүй болох даатгалын тохиолдол үүсэх асуудлыг дампуурах, дампуурсан тохиолдолд яах вэ гээд тодруулж байх шиг байна. Тэгэхээр бол харин энэ хуулиар 3 давхар хамгаалалтын тогтолцоог нэвтрүүлж өгч байгаа юм. Өнөөдөр бол хадгаламж зээлийн хоршоод нөөцийн сан байгуулаад, тэр нөөцийн сан нь өөрийнх нь эргэлтийн хөрөнгөд нь дотор нь ороод явж байгаа юм. Өөрөөр хэлбэл, нөөцийн сангаасаа зээл олгоод явж байна аа гэсэн үг. Тэр нь сан хэлбэртэй байж чадахгүй байна аа гэсэн үг.

Харин үүнийг албан ёсны нөөцийн сан байгуулах, тогтворжуулалтын сан буюу дээвэр байгуулахынхаа дэргэд энэ хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагааг жигдрүүлэх сургалт хийх, эрсдэлээс хамгаалах, эрсдэл үүсэх нөхцөлд нь бас тусалж дэмждэг энэ тогтворжуулалтын санг нь байгуулах, дээр нь хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгосноороо олон улсын жишигт нийцсэн 3 давхар хамгаалалтын тогтолцоог бий болгох юм байгаа юм.

Ингэснээрээ аливаа хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаа, энэ санхүүгийн хоршоодын үйл ажиллагаа доголдсоноор ард иргэдэд, энэ хадгаламж эзэмшигчдэд учирч байгаа эрсдэлийг хамгаалах гол механизм нь болж байгаа юм.

**Р.Сэддорж:** Ганбатын Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Өдрийн мэнд хүргэе. 2, 3 асуулт байна. Энэ хуулийн төслөөр бол энэ санхүүгийн хоршоо чинь зөвхөн гишүүддээ үйлчлэх үүрэгтэй. Одоо ингээд харахаар ийм жижиг банк шиг болгоод хаячих юм. Ер нь тийм болчихлоо шүү дээ. Энэ үйл ажиллагаануудыг нь нэмээд жижиг банк шиг болгочхож байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн төслийн талаар Монголбанкнаас, дээрээс нь арилжааны банкнуудаас, хадгаламж, зээлийн хоршоодоос ийм мэргэжлийн хэлэлцүүлэг хийж судалгаа авсан зүйл байна уу? Нэг дэх асуулт. Энд хариулаад өгөөрэй.

Хоёрдугаарх асуудал, ашгийн төлөө бус гээд энэ хадгаламж, зээлийн хоршоодын холбоо гэсэн нэр томъёог Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв гэсэн нэр томъёогоор сольж байгаа юм. Энэ ямар учиртай юм? Яагаад тэр холбоо гэдэг нэр томъёоноос, хууль дээр ашгийн төлөө бус гэсэн нэр томъёоноос татгалзаж энэ нэгдсэн төв болгож байгаа юм? Энэ нэгдсэн төв гэсэн нэр томъёог нь цаашаагаа хуулийн төсөлтэй нь уялдуулаад харахаар тэр хуулийн төслийн 11.2 дээр их сонин зүйл, заалт байгаад байгаа юм. Та бүхэнд уншаад танилцуулчихъя. Сумын насанд хүрсэн хүн амын 50-аас дээш хувийг гишүүнээр элсүүлсэн санхүүгийн хоршоонд орон нутагт хөгжүүлэх зориулалттай сан, ашигт малтмал ашиглах хайгуул олборлолт хийх аж ахуйн нэгжийн хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийг шилжүүлж гэж байгаа шүү, тухайн сумын хөгжил төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ ээ гэж байгаа юм. Үгүй ээ тэгэхээр энэ юу гэж ойлгох вэ? Баг, сумууд дээр очоод иргэдээ бүгдийг нь энэ хоршоондоо татаж 50-аас дээш хувийг нь аваад тэгээд тэрүүгээрээ дамжуулаад яах гэж байгаа юм манайх л бага зээл өгнө наашаа бай гээд нэг талыг ийм барьсан ийм шийдвэр энэ чинь асар олон хууль зөрчинө шүү. Эртхэн сануулчихъя.

11.3 дээр энэ хуулийн 11.2-т зааснаас бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүгийн хоршоодод нэгдсэн төвөөр дамжуулж олгоно гэж байгаа. Тэгээд энэ яах гэж байгаа юм? Энэ чинь хоршоо чинь уул нь гишүүд маань нийлээд дундаасаа 20-уулаа юм уу, 30-уулаа нийлээд бие биедээ санхүүгийн дэмжлэг үзүүлээд л ингээд л явах зохицуулалттай шүү дээ өөрсдийнхөө үзэл бодол дээр.

Тэгэхээр миний зүгээр харж байгаагаар энэ далд хэлбэрийн гаднаас орж ирдэг зээл, тусламжийг бүгдийг нь ийшийгээ авчирч тавьж байгаад зээл, тусламж өгч явах гэж байгаа юм уу? Тэгээд ийм 3 асуултыг эхлээд асууцхъя. Тэгээд тодруулъя. Их сонин хуулийн төсөл орж ирж байгаа юм. Гайхаад байгаа юм. Энэ чинь хоршоо чинь сайн дураараа нэгдэж бие биеийнхээ төлөө гишүүддээ үйлчилдэг ийм зохицуулалттай байсан юмыг бүр задалж том болгоод, банкны статус руу бараг оруулж ирээд, тэгэнгүүтээ дахиад хуулийнх нь зүйл заалт нь иргэдийг бүүр 50-аас дээшээ хувиар энэ хоршоонд нэгдэх юм бол энэ Орон нутгийн хөгжүүлэх сангаас мөнгө төгрөг өгнө энээ тэрээ гээд л энэ чинь аягүй сонин сонин юм болж байна шүү дээ.

Тэгээд хамгийн аймшигтай нь ингэж явж явж байснаа 51.1 дээр санхүүгийн хоршоо аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлнө гэххэж байгаа юм. Тэгээд энэний уялдаа холбоо их сонин байна.

**Р.Сэддорж:** Ажлын хэсэг эхлээд хэд хэн хариулах вэ? 6 номер.

**Т.Жамбаажамц:** Очирбат гишүүний асуултад хариулъя. Хадгаламж, зээлийн хоршоо гэдэг ийм нэртэй санхүүгийн бичил санхүүгийн институцийг зээлийн санхүүгийн хоршоо гэж нэрлэсэн. Үүнд бол зөвхөн хадгаламж, зээлийн үйл ажиллагаанаас гадна даатгалын төлөөлөгч, лизинг, факторинг, үүн дээр нэмээд төсөл, хөтөлбөр дамжуулан хэрэгжүүлэх ийм үйл ажиллагааг бол нэмэлтээр хадгаламж, зээлийн хошоодууд бол хэрэгжүүлэх боломжтой болж байгаа энэ хуулиар. Энэ ямар учиртай вэ гэхээр бас орон нутагт ялангуяа орон нутагт бол тодорхой төслүүд хэрэгждэг, орон нутгийн тодорхой иргэдэд чиглэсэн төслүүд хэрэгждэг. Энэ төслийг тодорхой тухайн орон нутгийн хүн амын нэлээдгүй оролцоотой, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн хувьд маш эрүүл саруул, удирдлага зохион байгуулалт, засаглалын хувьд маш сайтай ийм хоршоонуудаар бол дамжуулаад тэр хоршоодын гишүүдэд санхүүгийн, энэ бол зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанаас гадна санхүүгийн бус ялангуяа тэр нийгмийн соёлын хэрэгцээг хангах ийм мэргэжлийн институт болох юм. Бид нарын харж байгаагаар.

Тийм учраас одоо санхүүгийн тэр үйлчилгээнээс гадна соёлын гэдэг юм уу мэргэжлийн тэр бусад үйлчилгээнүүд дээр нь энэ төсөл, хөтөлбөрийг дамжуулах, дамжуулан зээлдүүлэх, ялангуяа орон нутгуудад бол тодорхой хэмжээний санхүүжилтүүдийг орон нутгийн иргэдэд чиглэсэн санхүүжилтүүд бол энэ мэргэжлийн институцээр нь дамжиж бол хэрэгжүүлэх бүрэн бололцоотой байгаад байгаа юм.

Тэгээд ер нь бол олон улсад манайд бол энэ хадгаламж, зээлийн хоршоонууд бол түрүүн бас хууль санаачлагч маань нэлээн дэлгэрэнгүй хэллээ. 2011 оноос бие даасан хуультай болсон. Түүнээс хойш одоогийн хэрэгжиж байгаа хууль бол зөвхөн энэ одоогийн хадгаламж, зээлийн хоршоонуудыг бол үндсэндээ бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан хууль байгаад байгаа.

Ялангуяа тэр энд бол бичил санхүүгийн институцийг өөрийг нь хамгаалдаг мэргэжлийн тэр дээвэр холбоо гээд байгаа тэр бол холбоо бол одоогийн Хадгаламж, зээлийн хоршооны хуулиар бол Үндэсний хадгаламж, зээлийн хоршооны үндэсний холбоо гэсэн нэр явж байгаа юм. Тэрийг нь шинэ хуулиар бол тэр дээвэр холбоо буюу дээвэр тэр төв гэдэг энэ бол өөрөө ТББ-ын статустай ажиллана. Гэхдээ энэ дээвэр төвд бол бүх хадгаламж, зээлийн хоршоонууд бол заавал гишүүнчлэлтэй байгаад тогтворжуулалтын санг нь удирдаад явдаг ийм санхүүгийн олон улсын нэгдсэн ийм яг стандартынх нь схемийнх нь дагуу бол зохицуулалт нь орж ирэх юм.

Цаашид бол ялангуяа бид бүхэн бол энийг бол илүү олон орон нутгийн шинжтэй, орон нутагт санхүүгийн үйлчилгээг нь хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл, хадгаламж, түүнээс гадна зөвхөн гишүүддээ даатгалын үйлчилгээ үзүүлдэг, лизингийн үйлчилгээ үзүүлдэг, бусад төрлийн тэр төсөл хөтөлбөрийг дамжуулан зээлдүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх тэр үйлчилгээг бол зөвхөн гишүүддээ хүргэдэг ийм онцлогоор бол хэрэгжүүлнэ гэж хуулийн төслөөр бол тусгасан байж байгаа.

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн нэмж хариулна.

**Д.Үүрийнтуяа:** Хоршоо гишүүддээ үйлчлэх ёстой гэж. Тэгэхдээ өнөөдөр бол бодит амьдрал дээр бид нар хуулийн тодорхой хязгаарлалтуудыг тавьж өгөөгүйгээс болоод хадгаламж, зээлийн хоршоод яг гишүүддээ үйлчилж байна уу гэвэл үгүй. Хадгаламж, зээлийн хоршоо бол үндсэндээ зээлийн үйл ажиллагааг гишүүн биш хүмүүстэй ч хийж байгаа. Зээл олгоод л гишүүн болгож байгаа. Тэгэхээр энэ нөхцөл байдлыг бид бол хязгаарлаж өгч байгаа юм.

Аж ахуй нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх энэ бол өнөөдөр уул нь хэрэгжээд явбал хуулиараа энэ заалт нь байгаа юм. Иргэний хуулиар хоршоо бол ашгийн төлөө бус байна аа гээд заачихсан. Ашгийн төлөө бус байгууллага бол орлогын албан татвар төлөх ёсгүй. Гэхдээ өнөөдөр хадгаламж, зээлийн хоршоодоос татвар авсаар байгаа. Цаашдаа санхүүгийн хоршоо бол гишүүдийнхээ төлөө үйлчлэх, олсон тэр ашгаа гишүүдийнхээ хөгжих, бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд зарцуулах ийм зохицуулалттайгаар олон улсын жишгээр нь оруулж өгч байгаа гэж бас ойлгох нь зүйтэй байх.

**Р.Сэддорж:** Очирбат гишүүн тодруулж асууна.

**Г.Очирбат:** Тэр судалгаанууд байна уу гэж асуусан хариулсангүй. Монголбанк, энэ хадгаламж, зээлийн хоршоод өөрсдөөс нь банк бус санхүүгийн байгууллагууд энд оролцож байгаа газруудад судалгаа байна уу гэсэн хариулж чадсангүй. Нэгд.

Хоёрт гэх юм бол тэр Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв гэдэг чинь тэр бүх хоршоо чинь энэ Санхүүгийн нэгдсэн хоршоодынхоо нэгдсэн төв гэдэгт очиж бүгд бүртгүүлэх гээд байна шүү дээ. Тийм байгаа биз одоо хуулиараа гишүүнээр ингэнэ. Тэгэхээр яг энэ дээр чинь нугалаас гарч ирээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэний чинь хойно ямар зорилго байгаа юм? Тэрийг аягүй тов тодорхой тайлбарлаад өгөөч. Тэгээд би түрүүн хуулийн заалттай нь хэллээ шүү дээ. Та нар тэгээд орон нутгийн өөрөө удирдах ёс руу ингэж дайрч орох юм уу? Сум, баг дээр чинь иргэдээсээ санал, судалгаа авч байгаад юу хийх вэ гэдэг юмаа хуулийн дагуу

явуулдаг шүү дээ. Тэгээд тэр рүү нь ингэж халдаж орох гэж байгаа юм уу? Наадах чинь аягүй тийм сонин юм оруулж ирчхээд одоо ингээд хэлэлцээд бид нар суугаад байх юм. Тэгээд тодорхой хариулаад өг л дээ. Судалгаануудаа хэлээд өг л дөө. Та нар чинь мэргэжлийн байгууллагынх.

**Р.Сэддорж:** Төсөл санаачлагч Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Очирбат гишүүний асуултад би хэд хэдэн асуултад нь хариулаад ажлын хэсгээс бас нэмж хариулъя. Хариулах боломж дээр минут нэмээд өгөхийг хүсье Байнгын хорооны даргаас. Хуулийн төслийг орон нутгуудад болон Улаанбаатар хотод хадгаламж, зээлийн хоршоод дээр хэлэлцүүлэг хийсэн. Бүх хадгаламж, зээлийн хоршоод руу албан бичиг явуулж бүх хоршоодоос санал авсан. Албан бичгээр санал авсан. Албан бичгээр авсан саналууд дээр хуулийн төсөлд тусгах, өөрчлөлт оруулах зүйлүүдийг хийсэн. Өөрчлөх боломжгүй байгаа зүйлүүддээ бас мэдэгдэж хэлэлцсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны энэ үндэсний холбоо бас энэ дээр ажилласан. Энэ хуулийн төсөл дээр ажилласан. Энэ дээвэр байгууллага болгож оруулж ирж байгаа нь бол олон улсын жишигт нийцүүлж холбоог нэгтгэж оруулж ирж байгаа. Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх энэ чиглэл рүүгээ цаашдаа бас бид ажиллах ёстой гэдэг зарчим дээр суурилж байгаа. Төсөл, хөтөлбөр дээр бол яг орон нутгийн тэр төсөвтэй улсын төсөвтэй холбоотой асуудлуудаар орно гэж бас ойлгож болохгүй.

**Р.Сэддорж:** Нэмж 9 номер Монголбанкнаас хариулах хэрэгтэй байх. Дараа нь Санхүүгийн зохицуулах хороо.

**Б.Эрдэнэхуяг:** Гишүүдийн энэ өглөөний өдрийн амгаланг л эргэн мэндчилье. Монголбанкны Хуулийн хэлтсийн захирал Эрдэнэхуяг байна. Монголбанкнаас 2026 оны 1 сарын 8-ны өдрийн албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд саналаа өгсөн байгаа. Энэ дээр бол хуулийн төслийн үзэл баримтлалыг бол дэмжиж байгаа. Энэ санхүүгийн хоршооны одоо байгаа цар хүрээг нэмэгдүүлэх, дээрээс нь энэ санхүүгийн хүртээмжийг банк санхүүгийн байгууллагын хүрч чадахгүй байгаа хүрээнд нэмэгдүүлэх энэ үзэл баримтыг бол дэмжиж байгаа.

Монголбанкны илэрхийлж байгаа байр суурь юу вэ гэхээр одоогийн байгаа санхүүгийн хоршооны төсөл дээр тусгасан зүйл нь банктай адилхан байдлаар буюу санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх хамгаалалтын элементийг энд оруулж өгсөн нь боломжгүй байна.

Яагаад гэхээр энэ өөрөө хаалттай буюу гишүүн өөрсдөө эрсдэлээ хүлээгээд явдаг энэ байгууллага дээр Хадгаламжийн даатгалын корпорацад хамааруулж хадгаламжийн даатгалын санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах энэ функцийг оруулж ирж байгаа нь энэ олон улсын зарчимтайгаа нийцэхгүй байна. Хөгжлийн бусад улсуудад буюу олон улсын энэ байгууллагууд дээрээс нь Америк, Европ гэсэн өндөр хөгжилтэй улсуудын хувьд.../минут дуусав./

**Р.Сэддорж:** 6 номер.

**Т.Жамбаажамц:** Очирбат гишүүний асуултад нэмээд тодруулга хэлье. Ерөнхийдөө энэ хадгаламжийн даатгалын тогтолцоо энэ хуулийн маш чухал

бүрэлдэхүүн хэсэг байгаа хуулийн төслийн. Олон улсын бид нар судалгаа бас хийж үзсэн. Ерөнхийдөө хадгаламжийн даатгалыг хэрэгжүүлдэг 2 үндсэн функц байгаад байна.

Нэгдүгээрт нь бол хадгаламжийн банк болон хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламжийн даатгалыг нэг институт хэрэгжүүлдэг. Австрали, Кени, Украин, Герман, Япон зэрэг орнууд бол нэг институт хэрэгжүүлдэг ийм загвар байгаад байгаа юм.

АНУ, Канад, Солонгос гэдэг энэ орнууд бол хадгаламжийн даатгалын корпорац буюу тэр институт нь 2 тусдаа хэлбэрээр яваад байгаа юм. 2 тусдаа хэлбэрээр. Тэгээд бид хэд бол хуулийн төсөл дээрээ хадгаламжийн даатгалын тогтолцоо нь өнөөдрийн нэгэнт бий болчихсон Монголын хадгаламжийн даатгалын корпорац дээр тэгэхдээ сан нь тусдаа байна. Хадгаламжийн сан нь банкныхаас тусдаа хадгаламж, зээлийн хоршооны сан нь тусдаа. Энэ хүрээндээ.../минут дуусав.

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулья 6 номер.

**Т.Жамбаажамц:** Энэ хүрээндээ хадгаламж эзэмшигчдийн мөнгөн хөрөнгийг найдвартай хамгаалах энэ талаасаа санхүүгийн итгэл даасан бичил санхүүгийн ийм институт болгох энэ олон улсынхаа жишгийн дагуу л оруулж ирсэн байж байгаа юм.

Хоёрдугаарт нь бол Очирбат гишүүн тэр орон нутгийн төсөвтэй, орон нутгийн хөгжлийн сантай бол энд ерөөсөө холбогдож байгаа зүйл бол байхгүй. Хамгийн гол нь орон нутагт иргэдийн өөрөөр хэлбэл иргэдийн санал, санаачилгаар орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон компаниуд ялангуяа энэ санхүүгийн хувьд нэлээн бэхэжчихсэн, удирдлага зохион байгуулалт нь их тодорхой, засаглал сайтай ийм орон нутгийн хоршоодод нь дамжуулаад төсөл, хөтөлбөрийг нь байдаг юм уу тухайн санхүүгийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлээд явал нөгөө орон нутгийн иргэдэд очих зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирна, зардал багасна, хүү багасна гэж бид нар бол харж байгаа.

Тэгэхээр хамгийн гол нь бид бүхэн бол энэ дээр тэр орон нутгийн хөгжлийн сантай ерөөсөө холбоотой зүйл байхгүй шүү гэдгийг бас энэ ташрамд тодруулж хэлье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Пүрэвийн Батчимэг гишүүн.

**П.Батчимэг:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсад 1996 оноос хойш үүсэн байгуулагдсан хадгаламж, зээлийн хоршоо өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа 200-300-гаад хадгаламж, зээлийн хоршоо сум орон нутаг хотод байгаа гэсэн мэдээлэл байгаа. Хуулийн төсөлд бол 178 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байна аа гэж гарсан байна. Санхүүгийн хоршооны тухай хууль, энэ нэмэлт, өөрчлөлт найруулгын төсөл энд гарч байгаа гол агуулга, нэмэлт, өөрчлөлтүүдийг бол хууль санаачлагчдын зүгээс өргөн мэдүүлж байгаа. Энийг бол харлаа.

Мэдээж аливаа нэгэн хуульд өөрчлөлт оруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахад тэнд хийгдэх тэр шаардлага, хэрэгцээ шаардлагыг бол бүрэн хангаж ажилладаг. Тэгэхээр мэдээж гадаад орнуудын туршлага өнөөдөр хадгаламж,

зээлийн хоршоо ахисан түвшинд яаж санхүүгийн хоршоо болж өөрчлөгдөж ажиллаж энэ сум, орон нутаг, алслагдсан хөдөө орон нутагт байгаа малчид иргэдийн аж амьдралыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх, бас тэр хуулийн төсөлд тусгаснаар нийгэм, соёлын хэрэгцээг нэмэгдүүлэх гэж бүүр нэмэлтээр заасан байна л даа. Тэгэхдээ нэршил аливаа юуны нэр, нэршил нэр томьёо өөрчлөгдөх бол нэг хэрэг. Тэгэхдээ тэр нь бол дандаа өөр тэрийгээ дагаж хувьсан хөгжиж байх ёстой гэж. Энэ хөгжлийн талаас нь бол би энэ Санхүүгийн хоршооны тухай хуулийг бол дэмжиж байгаа, дэмжиж байгаа.

Тэгэхээр ер нь энэ 2000-аад оны хадгаламж, зээлийн хоршооны тэр их хямрал, тэнд мэдээж хуулийн цоорхой энэ юмнууд бол байсан. Тэрийг дагасан л муу үр дагаврууд байсан. Хадгаламж, зээлийн хоршоо бол иргэдэд, Монголчуудад бол үр өгөөжөө өгсөн үү гэвэл өгсөн. Одоо зүгээр энэ санхүүгийн хоршоо болж өөрчлөгдсөнөөрөө одоо яаж хөгжлийн түвшинд яаж ажиллаж чадах вэ гэдгийг л харуулах ийм үе бас тулгараад байна л даа.

Тэгэхээр энэ 2000-аад оны хадгаламж, зээлийн хоршооны асуудал шиг, энэ хямрал шиг энэ гарах эрсдэлийг хэрхэн тооцож яг тэр эрсдэлээс хамгаалах бодит юм шалгуурууд хэрхэн тусгагдсан юм байгаа юм? Иргэдийнхээ тэр мөнгөн хадгаламжийг хамгаалах, одоо ерөөсөө л иргэд, малчид яах вэ гэхээр зээлгүй хүн малчин иргэд гэж байхгүй, аж ахуйн нэгж гэж байхгүй. Бүгд л зээлээс зээл рүү л амьдарч байгаа юм. Тэгэхээр энэ үйл ажиллагааны хувьд агуулагд энэ юмны хувьд хэдий хоцрогдсон.../минут дуусав./

**Р.Сэддорж:** 1 минут Батчимэг гишүүн.

**П.Батчимэг:** Эрсдэлийн удирдлагын стандарт, банк бус санхүүгийн байгууллага банкныхтайгаа хэр их ойртож дөхөж очих юм бол. Энэ дээр хууль санаачлагчдын зүгээс асуулт энэ асуултыг асууя. Ингээд л асуучихъя даа.

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн төсөл санаачлагч.

**Д.Үүрийнтуяа:** Батчимэг гишүүний асуултад хариулъя. Ер нь бол зээлийн хүүгийн түвшин өнөөдөр бас ард иргэдэд маш их дарамт болж байгаа энэ нөхцөлд бичил санхүүгийн зах зээлийг олон улсын жишгийнх нь дагуу хөгжүүлж, яг энэ гишүүддээ үйлчилдэг энэ санхүүгийн механизм руу нь оруулснаараа энэ зээлийн хүүгийн дарамтаас бол бид ард иргэдийг хөнгөлөх бас алхам болно оо гэж ингэж харж байгаа юм үр дүнг нь.

Монголбанк сая бас санал хэлж байх шиг байна. Өнөөдөр бол хуулийн хэлэлцэх эсэх, үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж байгаа. Гэхдээ бид хууль санаачлагчийн хувьд 2025 оны 10 сарын 20-ны өдөр Засгийн газарт санал авахаар албан бичгээ хүргүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бол 11 сарын 20-ны дотор санал ирүүлэх ёстой, хариу ирүүлэх ёстой. Хэрвээ ирээгүй бол саналгүй ээ гэж үзэх хуулийн заалттай. Өнөөдрийг хүртэл надад Засгийн газраас энэ хуулийн төслийн талаар санал ирээгүй. Тийм учраас би санал нэг байна аа гэж ойлгож байгаа.

Харин Монголбанк хадгаламжийн тэр даатгалын давхар хамгаалалтын тогтолцоо тэр бүхэл бүтэн бүлгээр нь бас энэ дээр бол олон улсын механизм, зарчимд нийцэхгүй гэдэг ийм ойлголтыг гаргаж байгаа юм байна аа гэдгийг би

өнөө өглөө сонссон. Тэгэхээр энэ бол зүгээр бид нар зарчимд нийцэж байна уу, үгүй юу гэхээс биш гэхээсээ илүүтэй өнөөдөр ард иргэдийн амьдралд Монголд үүсээд байгаа хадгаламж, зээлийн хоршоодод үүсэж байгаа энэ хүндрэл, эрсдэлийг давахад ямар боломжийг хууль, эрх зүйн орчныг бид нээх ёстой юм бэ гэдэг энэ нөхцөл байдлаа л харах ёстой.

Өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа хадгаламж, зээлийн хоршоо 3 дахь үе дээрээ явж байна гэж харж байгаа. Эхний үе бол үнэхээр энэ хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйгээс болоод маш том хямралыг хүний амь настай хүртэл бид нар авч явсан. Өнөөдөр хохирлоо барагдуулаагүй, 26 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулаагүй хохирчихсон иргэд явж байна. Хууль гарсан 15 жилийн хугацаанд нэг ч өөрчлөлт ороогүй. Энэ хугацаанд мөн дахиад хохирсон иргэд гарсан. Энэ юунаас болсон гэхээр энэ хадгаламж, зээлийн хоршоодыг бид давхар хамгаалалтын буюу даатгалын энэ давхар хамгаалалтынх нь тогтолцоог олон улсын жишгийнх нь дагуу хийж чадахгүй байгаагаас болж байгаа юм байна аа гэж үзэж яг энэ Монголбанкны эсрэг байгаад байгаа тэр бүхэл бүтэн заалтыг оруулж ирж байгаа юм.

Өнөөдөр арилжааны банканд болдог хадгаламж, зээлийн хоршоод бол энэ гишүүн нь өөрийнхөө хадгаламжийг даатгуулдаг байх эрхийг нь хязгаарлаж болохгүй л дээ. Тийм учраас энэ санхүүгийн зах зээл дээр хөрөнгө оруулалт хийж байгаа иргэн болгон хамгаалалтад байх ёстой. Энэ хамгаалалтыг нь төр мөнгө гаргаж хамгаалах биш, хохирсных нь дараа мөнгө өгдөг биш хууль, эрх зүйн орчноороо зохицуулж урьдчилан сэргийлэх алхмыг нь хийдэг байх ёстой.

Нөгөө талдаа энэ санхүүгийн хоршоод, санхүүгийн хоршоо гэж нэрлэж байгаа агуулга нь ч тэр. Ард иргэдийг бид нар үр хүүхдүүдээ санхүүгийн боловсролд багаас нь сургахад эхлүүлэх ёстой юм. Өнөөдөр хадгаламж, зээлийн хоршоо гэдэг нэр ард иргэдийн дунд, нийтийн дунд үнэхээр нэр хүнд нь уначихжээ. Ямар сайндаа манай боловсролын салбар систем нь хүртэл өөрөө сурах бичиг дээрээ хадгаламж, зээлийн хоршоонд мөнгө хадгалуулах чононд хонь хадгалуулахтай адилхан гэдэг агуулгатай зураг оруулж өгч байна шүү дээ.

Өнөөдөр ЕБС-ийн 7 дугаар ангийн хүүхдүүдийн дүрслэх урлагийн сурах бичиг дээр байж байгаа. Ийм ойлголтыг бид нар хүүхдүүддээ өгчхөөд яаж бичил санхүүгийн зах зээлийг Монгол Улсад хөгжүүлнэ гэж ярих вэ? Тийм учраас энэ санхүүгийн хоршоодын үүрэг бол санхүүгийн зах зээлийн ойлголт, энэ өрхийн төсөв, өрхийн эдийн засгаа хэрхэн авч явах суурь ойлголтыг олгохоос эхлээд нийгэмд олон талын ач холбогдол, үр нөлөөтэй болгох талаас нь хуулийн төслийн шинэчлэлийг бас хийсэн юм байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол үндсэн үйл ажиллагааны чиглэл нэмэгдэх, хамгаалалтын тогтолцоо нэмэгдэх, нийгэмд хүрч ажиллах үйл ажиллагааг нь нэмэгдүүлэх, дээр нь мөнгө угаах элдэв арга хэмжээнээс сэргийлэх зорилготой заалтууд орсон байгаа гэдгийг бас гишүүний асуултад тодотгож хариулъя.

**Р.Сэддорж:** Энэ ч хоршоодын банкны суурь гэсэн үг тээ? Жижгэрүүлсэн хувилбар гэсэн үг үү хоршоодын банк? Бадамдоржийн Пунсалмаа гишүүн.

**Б.Пунсалмаа:** Баярлалаа. Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байна. 2000-аад оны эхээр хадгаламж, зээлийн хоршоо маш ихээр байгуулагдсан. Бараг санхүүгийн пирамид шиг ажиллаад маш

олон хүмүүс тэндээс хохирсон байгаад байгаа юм. Тэгээд дараагаар нь бол хэд хэдэн хуулийн шинэчилсэн өөрчлөлт орж ирээд тэгээд нэлээн үйл ажиллагааг нь хумьж авсан л даа хадгаламж, зээлийн хоршооны. Одоо бол энэ хадгаламж, зээлийн хоршоо нь Санхүүгийн хоршооны тухай хууль нэртэйгээр нэрээ өөрчлөөд орж ирж байна.

Тэгэхдээ түрүүн үүссэн эрсдэлээс хамгаалах 3 хамгаалалт оруулж ирсэн байна л даа. Хоршооны нөөцийн сан үүсгэнэ, үйл ажиллагаа сэргээхэд зориулсан тогтворжуулалтын сан, хадгаламжийн даатгал гэсэн ийм 3 төрлөөр хамгаална. Өмнөх эрсдэлийг давтахгүй ээ гэж үзэж байгаа.

Гэхдээ энэ 3-хан өөрчлөлтөөр хадгаламж, зээлийн хоршоонд өмнө нь үүсэж байсан тэр олон эрсдэлийг хамгаалж чадна гэдэгт эргэлзэж байна. Яагаад гэхлээр хадгаламж, зээлийн хоршоо гэдэг бол хадгаламж эзэмшигчдийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байдаг. Арилжааны банкнууд яг ижилхэн бас хадгаламж эзэмшигчдийн хөрөнгөөр активаа бүрдүүлж, татан төвлөрүүлж байгаад зээл олгож байдаг. Өнөөдөр арилжааны банкнуудыг Монголбанк бол маш сайн хянаж байгаа. Тийм учраас системийн хувьд олон арилжааны банкнуудыг бий болгохгүй, үйл ажиллагааны хувьд хяналтаа тавьж ажилладаг.

Гэтэл хадгаламж, зээлийн хоршооны хувьд хадгаламж эзэмшигчдийг хамгаалах, зохист харьцааг нь бариулах тийм Санхүүгийн зохицуулах хорооны хувьд хэр ер нь хүртээмжтэй байх юм бэ? 2005 онд 900-аас 1000 хадгаламж, зээлийн хоршоо байгуулагдчихсан байсан. Одоо яг энэ борооны дараах мөөг шиг тэр олон хадгаламж, зээлийн хоршоо санхүүгийн зохицуулах байгууллага гээд ингээд санхүүгийн хоршоо нэртэйгээр ороод ирэх юм бол танай Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн энэ тал дээр зохист харьцааг нь хянаад ажиллаад ингээд хамгаалж чадах вэ гэдэг ийм асуулт байна. Энэ бол системийн хувьд аюулгүй байлгах, энэ олон хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалах маш том үйл ажиллагаа байгаа.

Хоёрдугаарт нь хэрвээ цаг байвал аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлнө гэгчхсэн юм байх юм. Энэ үйл ажиллагаа явуулж байгаа ашигтай ажиллаж байгаа бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвараа төлөх хэрэгтэй болох байх. Тэгээд энэ бас ТББ-ын шинж, ашгийн бус байгууллагын шинжтэй юм байна, тэгээд ашиг олох юм байна. Аж аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлүүлэх ийм хүсэлт орж ирж байна гэх мэтчилэн энэ 2 асуултыг асууя.

**Р.Сэддорж:** 6 номер ажлын хэсэг. Хэдэн номер вэ? 6 юу?

**Т.Жамбаажамц:** Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. Жамбаажамц байна. Пунсалмаа гишүүний яг болгоомжлоод байгаатай бол үнэхээр санал байна санал нэг байна. Ялангуяа манай дээр анх бол энэ хадгаламж, зээлийн хоршоо бол 2003, 4, 5 оны үед бол ямар нэгэн бие даасан зохицуулалтгүй ийм байсан. Энэ үед бол нийтдээ Монгол Улсад 900 гаруй, 970 гаруй ийм хадгаламж, зээлийн хоршоонууд бол үүсгэн байгуулагдсан байдаг. Тэгээд энэ бол зөвхөн иргэдээс асар их хэмжээний өндөр хүү амлаж, хүмүүсээс өндөр хэмжээний хадгаламж татаж тэгээд түүнийгээ мэргэжлийн бус хүмүүс удирдаж тодорхой ашиггүй хөрөнгө оруулалтын хөрөнгө оруулалтууд хийж үүнээс болж нийтдээ 26 хадгаламж, зээлийн хоршоо бол дампуурсан. 8301 хүн нийтдээ 72 тэрбум төгрөгийн хохирол

бол учирсан байдаг. Энэ бол бид нарын энэ хадгаламж, зээлийн хоршооны түүхэнд бол маш гашуун ийм түүх байдаг.

Санхүүгийн зохицуулах хороо 2006 оноосоо бол анх байгуулагдаж үйл ажиллагаа явуулсан. Тэгэхээр хорооны нэг гол зохицуулалтын салбар бол хадгаламж, зээлийн хоршоо байсан. Тэгээд байгуулагдсан цагаасаа 2 жил орчмын хугацаанд бол энэ тухайн үед үүсээд байсан хадгаламж, зээлийн хоршоонуудыг тусгай зөвшөөрөл олгох, бүртгэлжүүлэх, хууль зөрчсөн, ард иргэдийг хохироосон, хадгаламж эзэмшигчдийн хохироосон улсуудад бол цагдаагийн байгууллагад шилжүүлэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх ийм ажлыг бол зохион байгуулаад улмаар бие даасан, 2011 онд бол бие даасан хуулийг бол Санхүүгийн зохицуулах хорооноос тухайн үед боловсруулаад Улсын Их Хурлаар батлуулаад ингээд бол явсан. Ямар ч байсан Санхүүгийн зохицуулах хорооноос бол ийм зохицуулалттай, бүртгэлтэй мэргэжлийн жижиг бичил санхүүгийн ийм институт болгосон.

Санхүүгийн зохицуулах хорооноос ял ялгаагүй бусдаас эх үүсвэр татаж байгаа хадгаламж, зээлийн хоршоонуудын хувьд бол зохистой харьцаа, төлбөрийн чадвар гээд бүх шаардлагуудыг бол тавьж хангуулж ажилладаг.

Хадгаламж, зээлийн хоршоодыг зүгээр ний нуугүй хэлэхэд маш олон ийм юугаар хардаг тийм иргэдэд хүргэх үйлчилгээ гэдэг юм уу, иргэдэд хүрэх бас санхүүгийн тийм суваг гэж хараад түүнийг дамжуулаад их олон янзын тийм оролдлогууд бол хийх гээд байдаг. Өөрөөр хэлбэл хадгаламж, зээлийн хоршоо байгуулаад цаашаа ингээд иргэдэд чиглэсэн үйлчилгээ.

Энэ хууль гол нь батлагдсанаар батлагдсанаар санхүүгийн тэр нөөц сан, нөөц санг нь бол хадгаламж, зээлийн хоршоо өөр дээрээ байршуулаад явна. Тогтворжуулалтын сан байгуулна. Тогтворжуулалтын санг бол дээвэр холбоон дээр Тогтворжуулалтын сан төвлөрөөд үйл ажиллагаа нь доголдсон хадгаламж, зээлийн хоршоонуудад бол хяналт тавиад Тогтворжуулалтын сангаасаа зохион байгуулаад явна.

Хамгийн эцэст нь төлбөрийн чадваргүй болоод дампуурах эрсдэл дээр хүрвэл хадгаламжийн даатгалын тогтолцоо ингэж орж ирж байгаа юм. Тэгэхээр ийм 3 төрлийн хамгаалалтын тогтолцоо байж байж энэ салбар бол аюулгүй, эрүүл саруул, тэгээд энд бол төрийн зохицуулагч байгууллага бол хамгийн гол бид нарын хийх зүйл бол аюулгүй тийм санхүүгийн зах зээлийг үүсгэх ёстой, зохицуулах ёстой.

Тэгэхээр энэ хүрээндээ бол Санхүүгийн зохицуулах хороо бүрэн зохицуулалтыг нь тэр зохистой харьцаа, төлбөрийн чадварын зохицуулалтуудыг бол хангуулаад явна. Шаардлага хангахгүй тусгай зөвшөөрөл эзэмшигч хадгаламж, зээлийн хоршоонуудыг бол хадгаламж эзэмшигчдийн эрх ашиг бол тэргүүн ээлжид байдаг учраас үүн дээр нь хяналтаа тавиад хуульд заасан, энэ хуулийн төсөлд заасан албадлагын арга хэмжээнүүд байгаа. Албадлагын арга хэмжээнүүд байгаа. Торгох, үйл ажиллагааг нь зогсоох, түдгэлзүүлэх, тодорхой эрх хүлээн авагч томилох зэрэг ийм албадлагын арга хэмжээнүүдийг бол шат дараатай аваад хэрэгжүүлэхээр ийм байгаа.

Тэгээд энэний эцсийн дүн бол хадгал хадгаламж эзэмшигч жижиг гишүүдийн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг бүрэн хамгаалах найдвартай тийм санхүүгийн.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн нэмж хариулна.

**Д.Үүрийнтуяа:** Пунсалмаа гишүүний асуусан татвартай холбоотой асуудал дээр би хариулт өгье. Монгол Улсын иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т заасан байгаа хуулийн этгээдийн төрөл гэдэг дээр ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна аа гэж заасан. Хэрвээ ашгийн төлөө байх юм бол 33.1-ээр нөхөрлөл компанийн хэлбэрээр байгуулна аа гээд заачихсан. Тэгээд энэ Иргэний хуулийн заалтаар бол өнөөдөр холбоод, сангууд, хоршоонууд татвар төлдөггүй.

Гэхдээ манай татварын байгууллага бол хадгаламж, зээлийн хоршоодоос татвараа авдаг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар авсаар яваа. Энэ хуулийнхаа зохицуулалтаар хүртэл өнөөдөр бол төлөхгүй байх үндэслэлтэй. Тэгэхээр энэ гишүүдийнхээ төлөө үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус зөвхөн гишүүддээ зориулсан үйл ажиллагаа явуулдаг хоршооны хувьд бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөх нь хуулийн заалт нь одоо хэвээрээ байгаа ийм заалт юм байгаа юм. Тэгээд энийг л хуулийн төсөлд шигтгэж оруулж өгсөн байгаа.

**Р.Сэддорж:** Пунсалмаа гишүүн тодруулж асууна.

**Б.Пунсалмаа:** Тэгэхлээр хадгаламж эзэмшигчдийн хадгаламж хөрөнгийг хэрхэн хамгаалах вэ гээд асуугаад байгаа нь тэгэнгүүт нь Хадгаламжийн даатгалын тухай хуульд хоршооны хадгаламж эзэмшигч гишүүдийн мөнгөн хадгаламжийг хамгаалах зохицуулалт нь одоогоор тодорхой бус байна гэж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энийгээ яаж хамгаалахаар оруулж ирж байгаа юм? Жишээлбэл, 20 сая төгрөг гэдэг шиг энэ эрсдэл үүссэн тэр хадгаламж дээр хэмжээ зааж өгөх юм уу, эсвэл бүгдийг нь энэ эрсдэл үүсгэх юм бол тэрийг хаанаас энэ эрсдэлийг дааж зохицуулалт хийх юм гэдгийг асууж байгаа юм. Ямар хуулиар зохицуулагдах юм?

**Р.Сэддорж:** 4 номер.

**Ц.Алтантуул:** Алтантуул байна. Гишүүний асуултад хариулъя. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Санхүүгийн хоршооны тухай хуулийн 8 дугаар бүлгийг халамжийн даатгалын зохицуулалтыг оруулсан байгаа. Энд байгаа хуулийн төсөлд оруулснаар бол хадгаламж, зээлийн хоршоод, хадгаламжийн даатгалын санд мөнгө төвлөрүүлэх юм байгаа. Тэгээд эхний шатанд бол хадгаламж, зээлийн хоршоон дээр ямар нэгэн доголдол, асуудал үүслээ гэхэд бол нөөцийн сангийн хөрөнгөөр асуудлыг бол зохицуулна. Шаардлагатай бол Тогтворжуулалтын сан руу бол шилжүүлнэ. Тогтворжуулалтын сангийн хөрөнгө бол хадгаламж, зээлийн хоршоо бүрээс цуглуулсан хөрөнгөөс бүрдэнэ.

Тэгээд үйл ажиллагааг жигдрүүлэхэд чиглэсэн зөвлөн туслах үйлчилгээ, эсвэл зээл хэлбэртэй буцаан төлөгдөх нөхцөлтэй бас зээлийг гаргах юм байгаа. Хэрвээ энэ мөнгө хүрэлцээгүй, эсвэл гаргасан зээлийн дагуу дараа хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа сэргэхгүй дампуурах эрсдэл үүсэх юм бол халамжийн даатгалын тогтолцоо руу бол нөгөө төвлөрүүлсэн санал руугаа.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулах уу 4 номер? Болсон уу? 4 номер.

**Ц.Алтантуул:** Бид нарын тооцоолж байгаагаар бол хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг бол 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг даатгалд хамруулахаар бол тооцсон байгаа. Ингээд тооцоод үзэхээрээ бол өнөөдрийн хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн 96 хувь нь бол 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжтай байгаа учраас нийт гишүүдийн 96 хувь бол даатгалд хамрагдчихна гэж бол тооцож байгаа.

Шимтгэл, хураамжийн хувьд бол бас хадгаламж, зээлийн хоршоод өөрсдөө төлөөд явахаар байгаа. Төрөөс бол мөнгө гарахгүй. Банкны хадгаламжийн даатгалаас бол тусдаа сан үүсгээд явах юм байгаа юм.

**Р.Сэддорж:** Пунсалмаа гишүүн.

**Б.Пунсалмаа:** Яах вэ хадгаламж, зээлийн хоршоогоор бол энэ хямд эх үүсвэр бий болно гэж хэлээд байгаа шүү дээ энэ хуулиар. Тэгэхдээ энэ Нөөцийн сан, Тогтворжуулалтын сан, даатгал гээд маш их ийм эргэлтэд ордоггүй хөрөнгө төвлөрүүлээд байлгаад байх юм байна л даа хадгаламж, зээлийн хоршоон дээрээ. Энэ чинь өөрөө эх үүсвэрийг өндөр өртөгтэй болгож байдаг. Зээлийн хүүг бууруулахгүй, зээлийн хүүг өндөр байлгана л гэсэн үг. Тэгээд энэ даатгал чинь өөрөө 20 сая төгрөг хүртэл хэмжээтэй юм байна, лимиттэй юм байна. Тэгэхлээр хадгаламж, зээлийн хоршоон дээр хөрөнгө төвлөрүүлж байгаа хүн бол 20 саяас дээшээ хөрөнгө төвлөрүүлээд хэрэггүй ээ л гэсэн санаа юм байна л даа гэж ойлголоо зөв үү?

**Р.Сэддорж:** 4 номер тодорхой хариулаарай.

**Ц.Алтантуул:** Нөөцийн сангийн хөрөнгө бол хадгаламж, зээлийн хоршоон дээр өөр дээр нь байрлана. Тэр хөрөнгийг бол ямар зориулалтаар зарцуулах вэ гэдгийг л Санхүүгийн зохицуулах хорооноос бол бас тогтоогоод өгч байгаа. Тогтворжуулалтын сангийн хөрөнгө бол дээвэр байгууллага буюу хадгаламж, зээлийн хоршоодын нэгдсэн төв дээр бол байрших юм байгаа. Тэр бол бас тодорхой эргэлтэд ороод явах үед байгаа. Хадгаламж, зээлийн хоршоодод зээлээр гарна. Тогтворжуулалтын сангийн гадна байгаа нөгөө Хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө бол бид нарын тооцож байгаагаар бол Хадгаламжийн даатгалын корпорац дээр байрлана. Тэнд бас тодорхой хэмжээний хөрөнгийг удирдах менежментийн асуудлууд бас зохицуулалтууд хийгдсэн байгаа.

Дээрээс нь энэ хуулийн төсөл батлагдсанаар бас санхүүгийн хоршоод дээр зээлийн хямд эх үүсвэрүүд бол бас орж ирэх боломжууд бүрдэнэ гэж бид нар харж байгаа. Ялангуяа олон улсын байгууллагуудаас хэрэгждэг зорилтот бүлэгт чиглэсэн зээлүүдийг бол энэ төв хоршоогоор дамжуулаад анхан шатын хадгаламж, зээлийн хоршоодод, гишүүдэд, иргэдэд зориулсан байдлаар бол гаргах боломжтой тийм нөхцөл.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Батбаярын Жаргалан гишүүн.

**Б.Жаргалан:** Сайн байцгаана уу? Хадгаламж, зээлийн хоршоо бол иргэд сайн дурын үндсэн дээр нийлээд тэгээд өөрсдийнхөө мөнгөн хөрөнгийг нийлүүлээд нэг нэгэндээ зээлдүүлдэг ийм бичил санхүүгийн хэлбэр гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд өнгөрсөн хугацаанд бол хадгаламж, зээлийн хоршоотой

холбоотойгоор энэ схем нь өөрөө гажуудсаны улмаас бий болсон алдаа, завхралуудын талаар бас манай гишүүд ярьж л байна.

Тэгэнгүүт энийг нь засахын оронд бүүр ахиад гажуудал бий болгохуйц ийм үндсэн арга хэлбэрээс нь бүүр хальчихсан иймд юм оруулаад ирж байгааг би бол бас гайхаад байгаа юм. Тэгээд энэ дараах эх үүсвэрээс хөрөнгө бүрдүүлнэ гэнэ хөрөнгөө. Тэр гишүүний хувь хөрөнгө, гишүүний хадгаламж ойлгомжтой.

Дээрээс нь банк, санхүүгийн байгууллага нөгөө Санхүүгийн хоршоодын нэгдсэн төвөөс зээл авах юм гэнэ. Нөгөө Санхүүгийн хоршоодын нэгдсэн төв нь бас хаанаасаа зээл авах юм, яаж мөнгө төвлөрүүлэх юм? Ойлгомжгүй. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор авсан санхүүжилт гээд байгаа юм. Энэ чинь нөгөө анхныхаа санаанаас халиад байна шүү дээ. Тэр төсөл, хөтөлбөр нь явдаг бол түүгээрээ ингээд өөрсдийнх нь ийм төрийнхөө бүтцээр юм уу, аль эсвэл тусдаа тийм бүтцүүдээр явах нь зөв байхгүй юу даа. Түүнээс биш хадгаламж, зээлийн хоршоо гээд иргэдийн итгэлцэл дээр бий болсон сайн дурын нэгдлийг аваачаад бүүр ингээд ийм төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг нэгж болгож байна аа гэдэг чинь анхных нь энэ санхүүгийн хэрэгслийнх нь тэр утга санааг гажууд болж байна гэхлээрээ ахиад л ийм алдаа завхралыг бий болгоно оо гэдэг зүйлийг хэлэх гээд байгаа юм.

Тэгээд энэ 11.2 Очирбат гишүүн түрүүн уншиж өгөөд байсан. Сумын насанд хүрсэн хүн амын 50-аас дээш хувийг гишүүнээр элсүүлсэн санхүүгийн хоршоонд орон нутаг хөгжүүлэх зориулалттай сан, ашигт малтмал ашиглах, хайгуул, олборлолт хийх аж ахуйн нэгжийн хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийг шилжүүлж тухайн сумыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ ээ. Энэ тэр тухайн суман дээр бол энэ саяын дурдсан тэр орон нутгийн хөгжил, хөгжлийн сан энэ тэр чинь тусдаа зориулалтаар өөрсдөө ингээд тусдаа хуулийн зохицуулалттайгаар хэрэгжинэ шүү дээ. Тэгээд яах юм МАН тухайн сумын гишүүдийн 50 хувиас тухайн сумын иргэдийн 50 хувиас дээш хувийг оролцуулчхаад тэгээд ийм тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх гээд байгаа юм уу? Ийм л зүйл харагдаад байна шүү дээ.

Тэгээд энэ мэргэжлийн байгууллага нь яагаад энэ дээр Санхүүгийн зохицуулах хорооны гишүүд нь яагаад энэ дээр ийм юм хэлдэггүй, мэргэжлийнхээ тэр байгууллагын үйл ажиллагааг хамгаалахгүй ингээд суугаад байдаг юм бэ? Энэ чинь ингээд бүүр гажуудаад бүүр халиад сав хүрээнээсээ хальчихсан байна шүү дээ. Монголбанкны сая төлөөлөл хэлж байна энэ хадгаламжийн даатгалын корпорацыг бас ингээд энэ чинь ингээд анхных нь утга учраас гажуудуулах гэж байна аа гээд зөв шүү дээ. Тэгээд яагаад Монголбанкаа сонсдоггүй юм. Санхүүгийн зохицуулах хороо яагаад ингээд ийм мэргэжлийнхээ, салбарынхаа үйл ажиллагааг хамгаалаад ийм сонгодог утгаар нь явуулах юмаа боддоггүй юм бэ? Би Санхүүгийн зохицуулах хор, энэ Монголбанкны төлөөллийн яг энэ дээр яг мэргэжлийнх нь юмыг сонсмоор байна.

**Р.Сэддорж:** 6 номер хариулъя.

**Т.Жамбаажамц:** Жаргалан гишүүний асуултад хариулъя Жамбаажамц байна. Санхүүгийн зохицуулах хороо хуулиараа 4 үндсэн санхүүгийн салбар зохицуулж байгаа. Түүний нэг нь бол энэ бичил санхүүгийн салбар болох хадгаламж, зээлийн хоршооны салбар бол Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад 20 жилийн хугацаанд бол явж байгаа. 11 онд бол шинэ хууль бие

даасан анх удаа Монгол Улс хадгаламж, зээлийн хоршооны хуультай болсон. Монгол Улс бол хоршоологчдын 100 гаран жилийн түүхтэй ийм зохицуулалттай орон байгаа юм. Санхүүгийн зохицуулах хороо бол яг энэ салбараа хөгжүүлэх чиглэлээр ялангуяа энэ бичил санхүүг хөгжүүлэх чиглэлээр энэ хуулийн төслийг бол боловсруулаад олон улсын байгууллагуудтай хамтраад яг гадаад улсын жишигт нийцсэн байдлаар загвар хуулийн үндэслэж энэ хуулийн төслийг бол боловсруулсан.

Тэгэхээр энэ хуулийн төсөл бол яг энэ бичил санхүүгийн байгууллага, түүний дотор энэ гишүүддээ үйлчилдэг ашгийн төлөө биш энэ институцийн найдвартай, хамгийн найдвартай санхүүгийн институц байх, жижиг, дунд бизнес эрхлэгчид хүртээмжтэй байх, гишүүддээ санхүүгийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх ийм онцлогоор нь бол оруулж ирж байгаа юм боловсруулсан. Тэгээд Санхүүгийн зохицуулах хороо яг энэ өнөөдөр бол энэ тоонууд дээр бол харж байгаа нийт зээлийн нийт Монгол Улс дахь зээлийн 0.6 хувь нь л хадгаламж, зээлийн хоршооны зээл байгаа. Гэтэл нөгөө талдаа хүүгийн хувьд бол банкны зээлийн дунджаас арай өндөр ийм хэмжээтэй байгаад.

Гэтэл би түрүүн хэлсэн зээлийн чанар бол Монгол Улсад зээлийн үйл ажиллагаа явуулдаг 4 төрлийн институцээс хамгийн зээлийн чанар багатай нийт системийн хэмжээндээ бол 3 хувийн зээлийн чанар чанаргүй зээлийн хэмжээнд 3 хувьтай байгаа ийм институц байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар бол хамгийн гол зүйлүүд бол энэ хоршоог, хоршооны хадгаламж, зээлийнх нь санхүүгийн үйлчилгээг нь энэ санхүүгийн хоршоогоор дамжуулж явуулах энэ боломжийг бол энэ хуулиар бол зохицуулж өгч байгаа юм аа. Тэр таны энэ бол Жаргалан гишүүнээ хэлэлцэх эсэхийг нь шийдэж байгаа энэ хувилбар.

Дараагаар нь болоод таны тэр гаргаад байгаа тодорхой саналуудыг бол ажлын хэсгийн хүрээнд бол ярих бүрэн бололцоотой. Бид хэд бол төсөл, хөтөлбөрийг ингэж ойлгож байгаа хуулийн төслөөр тодорхой ийм зорилтот бүлгүүд рүү чиглэсэн олон улсын байгууллагууд, ялангуяа хөдөө орон нутагт алслагдмал бүс нутагт ийм ажлууд бол маш ихээр олон улсын байгууллагууд бол хийдэг. Тэр байгууллагууд бол үйл ажиллагаа нэлээн тогтвортой, засаглал сайтай, олон гишүүний оролцоотой ийм хадгаламж, зээлийн санхүүгийн хоршоодоор дамжиж тэр төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг багасгах, зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесийг санхүүжүүлэх ийм зорилготой бас төсөл, хөтөлбөрүүд хэрэгжих бүрэн бололцоотой байдаг.

Тэгэхээр энэ боломжийг нь энэ хадгаламж, зээлийн хоршоодод бол хуулиараа нээж өгч байгаа юм аа л гэж харж байгаа юм. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Жаргалан гишүүний асуултад нэмэлт тодруулга хийе. Хуулийн төсөл боловсруулж байх явцдаа бид бас амьдрал дээр хадгаламж, зээлийн хоршоодод тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлүүд, давуу тал, боломжууд юу байдаг юм тэрийг бид нар юунд алдаад байгаа юм бэ гэдэг дээр бас судалгаа хийсэн юм байгаа юм. Баян-Өлгий аймгийн Цэнгэл хоршоо гэж хоршоог би бас нэр дурдаад хэлчихье ээ гэж бодож байна. Маш сайн ажиллаж байгаа хоршоо. Жинхэнэ санхүүгийн хоршоо ямар хэлбэрээр байх вэ гэдгийг тэнд бол гаргаж

чадаж байгаа. Тэгээд тулгамдаж байгаа асуудлууд дээр бол яах вэ олон улсын төсөл, хөтөлбөрүүд гэдэг юм уу, эсвэл аж ахуйн нэгж байгууллагууд ч гэсэн орон нутгийн хөгжилд зориулаад хөрөнгө оруулалт хийе ээ гэхээр хэн нэгэн хүн, хэн нэгэн компаниар дамжуулаад хийхээс илүүтэй олон улсын жишиг энэ “Кредит Юнион” гээд энэ хадгаламж, зээлийн хоршоо санхүүгийн хоршоогоороо дамжуулаад хийдэг ийм жишгүүд байдаг юм байна.

Энэ боломжийг нээж өгөхөөр хийсэн заалт нь магадгүй гишүүдэд бас их буруу ойлголт төрүүлээд байгаа учраас хэдүүлээ энийг ажлын хэсгийн явцад бас дахин ярьж засах боломж гарах байх аа гэж ингэж бодож байна гишүүн.

**Р.Сэддорж:** Монголбанкнаас хариулах уу? 9 номер.

**Б.Эрдэнэхуяг:** Жаргалан гишүүний асуултад тодруулаад хариулъя. Ер нь Монголбанкны үндсэн зорилт бол үнийн тогтвортой байдал буюу зорилт. Хоёрдугаарх нь банк, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал байдаг. Энэ тогтолцооны тогтвортой байдлын нэг хэрэгсэл нь бол хадгаламжийн даатгалын корпорац гээд 2013 онд банкин дахь мөнгөн хадгаламж буюу хадгаламж эзэмшиж мөнгөн хөрөнгийг даатгаснаараа тухайн банкнаас мөнгөн хөрөнгийн хадгаламж найдвартай байдлыг хангах санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор авчихдаг.

Гэтэл энэ санхүүгийн хоршооны тухай зохицуулалт маань болохоор зөвхөн гишүүддээ өөрчлөлттэй. Гишүүд нь өөрсдөө эрсдэлээ хүлээх ёстой зүйлийг банкны тогтолцооны нийт эрсдэлд хамаарах буюу энэ хэрэгслийг өөр зорилгоор ашиглах гэж байгаа юм шиг ийм хууль хоорондын зөрчилдөөн үүсэж байгаа учраас энэ дээр бас анхаарч үзээч ээ гэсэн саналыг өгсөн. Үзэл баримтлалаа дэмжиж байгаа. Ажлын хэсгийн байгуулагдаад явахад энэ холбогдох заалтуудыг өөрчлөх боломжтой гэж үзэж байна.

**Р.Сэддорж:** Соронзонболд гишүүнийг нэмье. Батсүмбэрэл гишүүнийг нэмье. Жаргалан гишүүн тодруулж асууна.

**Б.Жаргалан:** Тэгэхээр энэ хадгаламж, зээлийн хоршоо гэдэг бүтцийн үндсэн үзэл санааг нэлээн гажуудуулсан, дээрээс нь баахан дайвар юмнууд нэмсэн. Дээрээс энэ энэ санхүүгийн хоршоо чинь болохлоор бүр ийм аж ахуйн үйл ажиллагаа хүртэл эрхлэх нь байна шүү дээ. Гишүүдийнхээ хүрээнд л гэгчихсэн байна. Тэгээд тэр аж ахуйн үйл ажиллагаа нь татвараас чөлөөлөгддөг гэх мэт.

Тэгэхээр ингэх юм бол манай санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал чинь бас хөгжихгүй. Ингээд нэг юман дээр юм овоолоод байх юм бол. Сүүлдээ түрүүн бараг ийм соёлын үйлчилгээ үзүүлнэ, соёл түгээнэ гээд ярчхав уу яачхав? Тэгээд бид нар ингээд ийм арай мэргэшсэн болохыг зориод байна шүү дээ. Ингээд аливаа юм чинь ийм хөгжлийнхөө үе шат руугаа явах ёстой байтал нэг юман дээр аваачаад бүр зомби шиг баахан юм овоолоод тэр зорилтот төсөл, хөтөлбөрүүд чинь ийм гишүүддээ үйлчилдэг байгууллагаар дамжиж хэрэгжиж болохгүй. Гишүүн бус хүмүүс нь яах юм? Энэ чинь бас хүний эрхийн асуудал биз дээ? Тэр олон улсын зорилтот хөтөлбөр энээ тэрээ янз бүрийн зүйлүүдийг чинь ийм гишүүдэд үйлчилдэг байгууллагууд руу чиглүүлчихлээр бусад хүмүүсээ хязгаарлачихна биз дээ?

**Р.Сэддорж:** 7 номер.

**Ж.Мөнх-Оргил:** Санхүүгийн зохицуулах хороо Мөнх-Оргил.Гишүүний асуулт тодруулъя. Санхүүгийн хоршооны хувьд бол энэ шинэчилсэн найруулгын төсөл дээр бол хуучин бол одоо байгаа Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль дээр бол Хадгаламж, зээлийн хоршоо нь хадгаламж болон зээлийн үйл ажиллагаа, үндсэн үйл ажиллагаа эрхэлж байгаа.

Дээр нь Санхүүгийн зохицуулах хорооноос нэмэлтээр бол зөвшөөрсөн тохиолдолд бол бусад үйл ажиллагааг бол эрхлэх бас боломжийг бол олгосон байдаг. Гэхдээ Зөвшөөрлийн тухай хууль батлагдсаны дараа бол өмнө нь бол энэ төсөл, хөтөлбөр дамжуулан хэрэгжүүлэх, тэгээд мөн энэ даатгалын зуучлалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зэрэг үйлчилгээнүүдийг бол үзүүлээд явдаг ийм туршлага бол байсан. Тэр үйл ажиллагаанууд бол зогссон байгаад байгаа.

Олон улсад бол яг энэ чиглэлийн санхүүгийн хоршоод бол яг олон төрлийн үйлчилгээ, санхүүгийн үйлчилгээг бол тухайн үйлчилгээнийхээ шаардлагыг хуульд заасан шаардлагуудыг хангасан бол нэмэлтээр эрхлээд явах боломжийг нь бол олгоод явдаг юм байна лээ. Тэгэхээр тэр хүрээнд бол хуулийн төсөлд тусчихсан явж байна аа гэж харж байгаа.

**Р.Сэддорж:** Соронзонболд гишүүн.

**Л.Соронзонболд:** Энэ Санхүүгийн хоршооны тухай хуулийн харахаар бол ер нь бол хоршоо маань нэлээн олон үйл ажиллагаа, чиглэл, үйл ажиллагааны чиглэл эрхлэх ийм боломжтой болж харагдаж байгаа. Даатгалын зуучлагч за энэ болж байна, факторинг байна, санхүүгийн түрээсийн үйлчилгээ байна. Яах вэ энэ дээр харин асуулт байгаад байгаа нь энэ. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1-д заасан 10 төлбөр тооцооны үйлчилгээг Монголбанкнаас зөвшөөрөл авч чадах юм бол эрхэлж болно оо гэж зааж байгаа байхгүй юу. Энэ төлбөр, тооцоотой холбоотой үйлчилгээ эрхлэгч чинь бол ер нь бас нэлээн их тодорхой хэмжээний ийм хөрвөх чадвар, төлбөрийн чадвар гээд ийм олон асуудлууд үүснэ.

Тэгэхээр энэ эрсдэлийг манай санхүүгийн хоршоо маань ялангуяа суманд үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн хоршоо энэ ийм хэмжээнд үйл ажиллагаа явуулж чадах уу үгүй юу? Энэ заалтыг заавал ингэж оруулах болсны шалтгаан нь юу вэ гэдэг ийм асуулт байна.

**Р.Сэддорж:** 4 номер.

**Ц.Алтантуул:** Алтантуул байна. Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн хоршооны тухай хуулийн төсөлд бид нар хадгаламж, зээлээс гадна зарим төрлийн үйл ажиллагааг нэмэлтээр эрхлэх боломжийг бол нээж өгсөн байгаа. Энэ дотроо бол Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан үйл ажиллагааг хэрвээ шаардлага хангах юм бол хадгаламж, зээлийн хоршоо эрхэлж болохоор бол оруулсан байгаа. Энэ нь бол ерөөсөө өнөөдрийн түвшинд бол магадгүй хадгаламж, зээлийн хоршоодын шаардлага, шалгуурыг нь бол хааж хангаж бол чадахгүй. Гэхдээ үйл ажиллагаагаа эрхлээд явахад бол магадгүй 2 жилийн дараа, 3 жилийн дараа эрхлэх боломжийг нь бүрдүүлж өгөхөөр хуулийн зохицуулалтыг нь бол тусгаж оруулж өгсөн байгаа.

Энэ жишээлэх юм бол мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа байгаа. Мөнгөн гуйвуулгын үйл ажиллагааг бол түрүүн Мөнх-Оргил даргын хэлдгээр Хорооноос

зөвшөөрөл авах хэлбэрээр өмнө нь явж байсан Зөвшөөрлийн хуультай холбоотойгоор бол эрхлэх боломжгүй болсон өнөөдрийн хувьд хадгаламж, зээлийн хоршоод. Энэ мөнгөн гуйвуулгын үйлчилгээ ямар ач холбогдолтой вэ гэхээр орон нутагт амьдардаг ээж нь, аав нь хүүхдэдээ мөнгө шилжүүлэх шаардлага гардаг.

Гэхдээ сумын түвшинд, багийн түвшинд байгаа зарим иргэдийн хувьд бол Мобайл банк ашиглаж тэр бүрчлэн чаддаггүй, утасных нь шаардлага тэр шалгуурыг бас хангадаггүй. Тэр тохиолдолд бол хадгаламж, зээлийн хоршоон дээр ирээд өөрийнхөө данснаас мөнгөө хотод байгаа хүүхэд рүүгээ шилжүүлэх тэр үйлчилгээг бид нар эрхэлж явуулах боломжийг нь бол байсныг зогсоосон. Тэрийгээ бол бас цаашид эрхлэх орон нутгийн түвшинд малчдын хэрэгцээ, шаардлага тохируулах хэлбэрээр бас шаардлагыг нь хангадаг юм бол эрхлүүлэх байдлаар бол тусгаж өгсөн байгаа.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүний нэрийг нэмье. Соронзонболд гишүүн тодруулж асууя.

**Л.Соронзонболд:** Түрүүн манай Үүрийнтуяа гишүүн ярьж байна Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын “Цэнгэл хөгжил” хадгаламж, зээлийн хоршоо сайн үйл ажиллагаа явуулдаг аа гээд. Миний ойлгосноор бол тухайн хоршоо маань сумдаа бол бараг Хаан банкны салбартай өрсөлдөхүйц хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сумынхаа хамгийн өндөр татвар төлөгч байсан санагдаж байна. Тэгэхээр энэ одоо Хоршооны тухай хууль дээр ерөнхийдөө хоршоо маань аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхгүй байх заалт одоо ч гэсэн байгаа гэдэг асуудал яригдаад байгаа.

Тэгэхээр тодорхой хэмжээнд энэ хоршоо маань өөрөө ингээд үйл ажиллагаа явуулаад ашигтай ажиллаж байгаа юм чинь маань аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхгүй байя гэдэг энэ үндэслэл оруулж ирээд байгаа шүү дээ. Энэний гол үндэслэл нь юу байна аа гээд. Яагаад гэхээр тухайн хоршоо чинь бол сумдаа хамгийн том татвар төлөгч болдог. Сумынхаа төсвийн орлогод бас тодорхой хэмжээний хувь нэмэр оруулдаг ийм байдаг. Гэтэл одоо болохоор огт татвар төлдөггүй болгочихоор энэ маань бас зөв үү, буруу юу гэдэг ийм асуулт байгаад байна.

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн хариулна.

**Д.Үүрийнтуяа:** Би түрүүн Пунсалмаа гишүүний асуултад хариулахдаа бас яг тодорхой хариулсан хуулийн заалттай хариулсан. Иргэний хуулиар өнөөдөр ашгийн төлөө бус аж ахуйн нэгж байгууллага гэдэгт холбоо, сан, хоршоо орж байгаа юм. Хэрвээ ашгийн төлөө байгууллага байна аа гэвэл бид аж ахуйн нэгж байгууллага, компани байгуулах хэрэгтэй боллоо л гэсэн үг. Тэгэх юм бол энэ үндсэн агуулга нь зөрчилдөөд явчхаж байгаа юм л даа.

Сүүлийн 4 жилийн хугацаанд нийтдээ улсын төсөвт 6.5 тэрбум төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлсөн байдаг энэ 178 хоршоо нийлээд. Хамгийн сүүлд 2025 онд 1.8 тэрбум төгрөг төлсөн байдаг юм. 1 аж ахуйн нэгж 1 хоршоодод аваад үзэх юм бол хоршоодынхоо гишүүдийг чадавхжуулах, хоршоодынхоо гишүүддээ энэ мөнгөө зарцуулах, энэ аж ахуйн нэгжүүд орлогын албан татвар төлөхийн тулд хоршоо чинь үйл ажиллагаа явуулахын тулд эргээд яг банк шиг гүйлгээний хураамж, данс хөтөлсний хураамж хүртэл авч байгаа байхгүй

юу. Энэ нөхцөл байдлыг нь арилгах өөрсдөд нь боломж олгохыг энэ.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Батсүмбэрэл гишүүн асуулт асууна.

**Н.Батсүмбэрэл:** Энэ хууль хэлэлцэгдээд явах байх гэж би бодож байна. Тэгээд мэргэжлийн хүмүүс нь үгээ хэлэх байх. Мань мэтийн мэргэжлийн биш хүмүүс нь бас өөрсдөө санаа бодлыг хуваалцаад явна. 2, 3-н юм бас сонирхолтой байгаад байна л даа. Энэ хадгаламж, зээлийн хоршоо татвар төлдөггүй байх асуудлыг бол гишүүд хөндөөд байгаа. Энийг зайлшгүй хөндөх ёстой. Хадгаламж, зээлийн хоршоо чинь саяхан бол барилга бариад, сугалаа сугалуулаад, сугалсан хүнд нь Барон Унгернын алтыг өгнө гээд амлаад явж байсан байгууллага мөн биз дээ? Би мартаад буруу бодоод байна уу? Хадгаламж, зээлийн хоршооноос болж хүний амь насыг хохироож байсан. Зарим гишүүд нам, улс төр яриад байх шиг байгаа юм. Аль намын ч билээ хотын дарга хороо болгон дээр хадгаламж, зээлийн хоршоо байгуулаад л улс төржөөд давхиад байсан. Тэр юу болсон юм? Энэ Санхүү зохицуулах хороод ер нь Улаанбаатар хотод банк бус санхүүгийн байгууллага билүү хадгаламж, зээлийн хоршоо ч билүү байгуулчихсан тэр юмыг шалгасан уу? Ер нь тэрэнтэй холбоотой ямар дүгнэлт байдаг юм? Энийг хэлж өгөөч.

Хоёрт нь энэ Их Хурал дотор чинь банк бустай, эсвэл банк бусаас хамааралтай хэдэн гишүүн байдаг юм? Энийг ер нь та нар судалсан юм уу? Энэ хэлэлцүүлгийн явцад чинь нөгөө нөхдүүд чинь ашиг сонирхол нь хөндөгдөөд уйлж майлаад явчих вий дээ. Нөгөө тэр хэдийнхээ бас юмыг нь бодсон юм байгаа биз дээ та хэд чинь бас? Зовлон нь бөөн юм болно шүү дээ. Нөгөө хуулийг чинь явуулахгүй, нөгөө юм нь хүндрээд, ээж, аав нь утасдаад, ах, дүү нар нь яриад, нөгөө банк бус нь мөнгө санхүүгийн өгөхөө болилоо гээд хэдэн гишүүд маань уйлчих вий дээ. Тэгэхээр энэ банк бусаас хамааралтай гишүүд хэр олон байдаг юм. Энийг та бүхэн хэлж өгөөч.

Тэр хууль санаачлагч тэр татвар төлдөггүй байдал ер нь яагаад хийж байгаа юм бэ? Татвар төлөхгүй байснаар ямар сайн юм үүсэх гээд байгаа юм? Түрүүн би хэлсэн татвар төлөхгүй байх тухай сугалаа сугалуулаад л, байшин бариад л, хороолол үүсгээд л явдаг л байгууллага шүү дээ. Тэгээд энэнээс мөн чанарын хувьд яаж өөрчлөгдөх гээд байгаа юм? Энэ асуултуудад хариулт авъя.

**Р.Сэддорж:** Ажлын хэсэг хариулъя 4 номер.

**Ц.Алтантуул:** Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Хадгаламж, зээлийн хоршооны татвартай холбоотой асуудал хөндөгдөж байна. Хадгаламж, зээлийн хоршооны хувьд үйл ажиллагааны орлогоос бол аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 10 хувиар төлөөд, тэрний дараагаар үлдсэн мөнгөнөөс нь бол гишүүдэд хэрвээ ноогдол ашиг тараах юм бол гишүүн бүрд очсон хөрөнгөөс бас хүн амын орлогын албан татварын хураамжийг бол бас аваад явдаг. Энийг харах юм бол хадгаламж, зээлийн хоршооны хувьд бол орсон 1 ашгаас 2 удаагийн татвар бол төлөгдөөд явж байгаа. Яг хоршооны онцлогийг нь хараад үзэх юм бол санхүүгийн үйлчилгээнээс гадна нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангана гэдэг чиг үүрэгтэй байгууллага. Тэр нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг бол үйл ажиллагаанаас олсон орлогоосоо тодорхой хэмжээний сангууд үүсгэж явдаг юм байгаа юм. Тэр сангуудаас хуваарилах мөнгийг л ерөнхийдөө татварт аваад

гишүүдэд очих үйлчилгээ, өгөөж буураад байна гэж бол онолын түвшинд бол олон улсад бас хадгаламж, зээлийн хоршоодын хувьд бол үздэг.

Гаднын хадгаламж, зээлийн хоршоо дээр авч үзэх юм бол жишээлэх юм бол Тайландын хадгаламж, зээлийн хоршоог би жишээ болгож хэлье. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүнд гэрлэсэн бол төрөөс өгдөг мөнгийг хадгаламж, зээлийн хоршоо нь өөрөө өгдөг. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн хүүхдэдээ бол хүүхдийн мөнгийг нь хоршоо нь өгдөг. Энэ мөнгийг бол татвараас чөлөөлсөн мөнгөөр өгдөг буюу нийгмийн үзүүлдэг, төрөөс үзүүлдэг нийгмийн үйлчилгээг хадгаламж, зээлийн хоршоод иргэдэд хүргэж байна гэж бол тооцдог юм байна лээ. Энэ жишиг бол зөвхөн Тайландаар хязгаарлагдахгүй бусад Америк болон бусад орнуудад бас ижилхэн байгаа. Манай хувьд ч гэсэн орон нутгийн түвшинд ялангуяа хадгаламж, зээлийн хоршоод дээр бас нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг гишүүдэдээ бас хүүхдүүдийг нь сургах хэлбэрээр, эсвэл шинэ жилээр, хүүхдийн баяраар хүүхдийн баярын бэлгийг нь өгдөг, ахмадуудад цагаан сараар тавгийн идээг нь бэлдэх хэлбэрээр явдаг юм байгаа юм.

Тэгэхээр татвартай холбоотой асуудал бол энэ байгууллагын хувьд бол бас олон талын ач холбогдолтой. Нөгөө талаар өөр бас зээлийн хүүг тогтооход ч гэсэн татварын нөлөөлөл бас ордог. Тийм учраас хуулийн төсөл дээр явж байгаа зээлийн хүү бууруулах агуулга дотор бас энэ татварын чөлөөлөлт маань бас давхар хамаарч байгаа.

Дараагийн асуулт болохоороо нийслэлтэй холбоотой байгуулсан хадгаламж, зээлийн хоршоодын талаар мэдээлэл өгье. 2014 онд НИТХ-аас бичил бизнесийг дэмжих, нийслэлийн ядуурлыг бууруулах санг байгуулж Улаанбаатар хотод 14.3 тэрбум төгрөгийг хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулж зээл хэлбэрээр бол олгосон байдаг. Ингэхдээ бол 152 хороогоор дамжуулаад 118 хадгаламж, зээлийн хоршоог нийслэлээс зохион байгуулаад шинээр байгуулж бол мөнгийг нь олгосон. Энэ зээлүүд тухайн үед бол хадгаламж, зээлийн хоршооны талаар төдийлөн ойлголттой биш шинэ хоршоод байгуулж олгосонтой холбоотой.

Дээрээс нь тухайн үед байгуулсан зээлийн гэрээнүүд нь эргэн төлөгдөх нөхцөлгүй тусламж хэлбэрийн гэрээ байгуулж олгосонтой холбоотой бас эргэн төлөлтийн асуудал бол үүссэн. Энийг бол 2018 онд Санхүүгийн зохицуулах хорооноос бас ажил хэрэг болгоод эргэн төлөгдөх график гаргаад хадгаламж, зээлийн хоршоодоос бол татан төвлөрүүлсэн.

Өнөөдрийн байдлаар бол 14.3 тэрбум төгрөгийн 50 хувь орчим буюу 8 тэрбум төгрөг нь бол нийслэлийн төсөвт бол эргэн төлөгдсөн. Хадгаламж, зээлийн хоршоодын төлөгдөөгүй зээл дээр бол нийслэлийн зүгээс бас шүүхэд нэхэмжлэл гаргаад эргэн төлөлтийг нь бас хийлгээд явж байгаа. Хорооны зүгээс бол шинээр байгуулсан 118 хадгаламж, зээлийн хоршооноос өнөөдрийн байдлаар бол үйл ажиллагаа нь хэвийн, тогтож үлдсэн 26 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа. 92 хадгаламж, зээлийн хоршооны бас тусгай зөвшөөрлийг бол өнгөрсөн хугацаанд хүчингүй болгосон байгаа.

**Р.Сэддорж:** Их Хурлын гишүүн Үүрийнтуяа.

**Д.Үүрийнтуяа:** Хадгаламж, зээлийн хоршоод сугалаа явуулдаг, байр өгдөг маш их ашиг олдог гэж. Тэгээд яг үнэндээ энэ бол хадгаламж, зээлийн хоршооны зарчмаараа ажиллахгүй байгаа томоохон компанийн дэргэдэх хэд хэдэн

хадгаламж, зээлийн хоршоодтой холбоотой асуудал гэж ойлгож болно. Яг энэ томоохон бизнес эрхэлдэг, хажуудаа томоохон бизнестэй энэ хадгаламж, зээлийн хоршоод бол хуулийн төслийг эсэргүүцэж байгаа. Дэмжихгүй албан бичгүүдээ ч ирүүлж байгаа.

Яагаад гэхээр энэ хуулиар тэр том компанийн дэргэдэх аж ахуйн нэгжүүд хадгаламж, зээлийн хоршоодын эрх ашиг бол хязгаарлагдах юм. Яг жинхэнэ санхүүгийн хоршоод орон нутагт иргэдэд хүрсэн бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх энэ механизмаараа ажиллах боломжийг нь энэ хуулиар олгож, хуулийн хязгаарлалтуудыг нь тогтоож өгч байгаа. Тийм ч учраас бас асуудлууд үүсэж байгааг мэдэрч байгаа.

Гэхдээ өнөөдөр бол яг аль гишүүн, тэр гишүүн, энэ хадгаламж, зээлийн хоршоодтой гэдэг юм уу ББСБ-тай холбоо.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Батсүмбэрэл гишүүн.

**Н.Батсүмбэрэл:** Үгүй ээ юу юм л даа энэ чинь и интернэтээр баахан байгаа шүү дээ. Монголбанкны дарга нар бүгдээрээ л банк бустай, хадгаламж, зээлийн хоршоодтой юм байна тэгээд л Google-дээд үзвэл дүүрэн байгаа. Санхүүгийн зохицуулах хороо бас ямар байдгийг би мэдэхгүй. Тэгээд энэ нөхцөл байдал сайжрах гэж байгаа явдал нь бол их сайн юм байна аа гэж би хувьдаа бодож байгаа. Тэгээд тэр Нийслэл хотын төсвөөс худлаа хэлээд алга болчихсон мөнгөний тал нь буцаж орчихсон юм байна. Тэгээд талыг нь яах юм бэ? Энийг тодруулж хариулж өгөөч. Өөр юман дээр бол бас арай өөр үйлчлэл яваад байдаг юм байна лээ. Бас энэ дээр ямар байдаг юм? Нэг.

Хоёр дахь нь сая Үүрийнтуяа гишүүн өөрөө хэллээ шүү дээ. Тэгээд тэр нөлөөлөлтэй, идэвхтэй томхон компаниуд ингээд энэ хуулийг эсэргүүцээд байгаа байна. Тэгээд тэрийг нь зарлах хэрэгтэй шүү дээ. Ямар компаниуд эсэргүүцээд байгаа юм. Одоо удахгүй гар, хөлөө шургуулна тэр том компаниуд, том банк бус, санхүүгийн зохицуулах юу билээ хадгаламж, зээлийн хоршоонууд. Тэгээд эд нар чинь аюултай нөхдүүд юм шиг байгаа шүү дээ энэ юм юмнуудыг уншиж байхад тийм ээ. Тэгэхээр энэ хамааралтай Их Хурлын гишүүдийг нь бол зарлах хэрэгтэй.

**Р.Сэддорж:** Санал хэлэв үү тээ? Сайнзориг гишүүнийг нэмээрэй. 4 номер.

**Ц.Алтантуул:** Нийслэлтэй холбоотой зээлийг бол шүүхийн замаар яваад бас тодорхой хугацааны дараа эргэн төлөгдөөд гүйцнэ гэж бол хүлээлттэй байгаа. Яг зээлтэй холбоотой эргэн төлөлтийн асуудлыг бол Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв бол хариуцаад явж байгаа. Өмнө нь бол төсөл хэрэгжиж байх хугацаанд буюу тэр 2015-аас 20 оныг хүртэл бол Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар хариуцаж байсан. Дараагаар нь бол нийслэлийн дотоод бүтцэд бас өөрчлөлт ороод Жижиг, дунд үйлдвэрлэлийг эрхлэхийг дэмжих төв хариуцаж байгаа.

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд бол улирал бүхэн мэдээг нь аваад ерөнхий төлөлтийг нь бол графикийн дагуу явж байна уу үгүй юү гэдгийг бол мэдээг нь хараад явж байгаа.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Д.Энхтүвшин:** Энэ юутай үйл ажиллагаатай холбоотой асуулт байна 6.1 дээр болохоор хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхэлнэ, гээд тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа эрхэлнэ гээд заачихсан байна. Тэгэнгүүт 4 дүгээр зүйл дээрээ санхүүгийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл гээд. Тэрнийхээ 13.1 дээр нь санхүүгийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл гээд биччихсэн байна. Тэгэхээр энэ юу чинь санхүүгийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл юм уу, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл юм уу? Энийгээ тодорхой болгож өгөөч. Тэгэхгүй бол хууль дээр 2 өөр нэр, 1 тусгай зөвшөөрөл 2 өөр нэртэй яваад байна. Тэгээд энийг эхлээд асуултаа асуучаад тэгээд тодруулъя.

**Р.Сэддорж:** Хариулт 7 номер.

**Ж.Мөнх-Оргил:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хороо Мөнх-Оргил байна. Хуулийн төсөл дээр бол туссан байгаагаар бол яг санхүүгийн хоршооны бол яг үндсэн үйл ажиллагаа нь бол эхлээд бол хадгаламж болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгаа. Тэгэхээр энэ 6.1-д заасан үйл ажиллагаа эрхэлнэ гэдэг үндсэн зохицуулалт нь бол байгаад байгаа гэсэн үг.

Тэгээд 6.2-т нь бол нэмэлтээр бол зөвшөөрлийн үндсэн дээр бол явна гэсэн үг. Хадгаламж, зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гэсэн үг.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтүвшин:** Хэрвээ та хэд юу талаасаа хадгаламж, зээлийн үйл ажиллагаа л гэж үзэж байгаа бол энийгээ хоёрдмол утгатай ийм тусгай зөвшөөрлийг өөр 2 өөрөөр нэрлэмээргүй байна. Санхүүгийн хоршооны үйл ажиллагаа гэдэг тэр 4 дүгээр бүлгийн гарчгаа хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл. Тэгээд тэр 13.1 дээр гарчгаа ч гэсэн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргагч нь гэдэг байдлаар явахгүй бол энэ хууль дээр 1 ойлголтыг 1 тусгай зөвшөөрлийг 2 өөрөөр хэлчихсэн. Тэгээд би харин гайхаад байсан юм. Нөгөө дагасан хууль дээр Зөвшөөрлийн тухай хууль байхгүй мөртөө яг хууль дээр харахаар 2 тусгай зөвшөөрлийн асуудал харагдаад байна лээ. Хэрвээ дэмжигдвэл энийгээ, хэлэлцэх эсэх нь дэмжигдвэл энийгээ засах хэрэгтэй санагдаж байна.

Дээр нь хуулийн бичиглэл талаасаа ч гэсэн 77, 78 дээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүчингүй болгох харилцааг тусад нь оруулчихсан байна лээ. Тэгсэн мөртөө 14 дээр болохоор тусгай зөвшөөрөл олгох харилцаа нь байж байгаа. Тэгэхээр уул нь энэ тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцаануудаа бүгдээрэнг.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Саналыг хүлээж авлаа. Ажлын хэсэг саналыг сайн бичиж тэмдэглэж аваарай. 1 минут Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** Тэгээд саяын энэ хууль бичиглэл талаасаа бодно биз. Дээр нь энэ 13.1.6 дээр бүх гишүүдийн хурлаар баталсан 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө шаардаж байна. Тэгэхээр яг ийм бодитой биш жишээлбэл л ямар ч аж ахуйн нэгжийн хувьд бол 3 жилээр бизнес төлөвлөгөөгөө батлаад ингэдэг юу бол бараг байхгүй шахуу. Тэгэхээр ийм бодитой байна биш нэгд.

Хоёрдугаарт энэ нь өөрөө яг бизнес төлөвлөгөөг нь авах гэж яах гэж байна тэр доторх гол шаардлагатай мэдээллүүдээ л оруулчихвал зүгээр юм биш үү гэсэн ийм санал байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Би их мэргэжлийн юманд нь их санал хэлж чадахгүй. Зүгээр хуулийн этгээдийн хэлбэр, түүнийг дагасан засаглалын асуудлаа та нар сайн бодсон уу гэдэг дээр л хэлэх гэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Иргэний хуулийн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөл дээр сан, холбоо, хоршоо байж байгаа. Хоршооны асуудал бол бас бусад орны практик дээр ч гэсэн маргаантай. Энийг ашгийн төлөө болгох уу, ашгийн төлөө бус болгох уу гэдэг маргаантай л яваад байгаа юм. Энэ хуулийн этгээдийн хэлбэр талаасаа засаглал яригддаг. Энийг дагасан эрсдэлийг хуваарилах онол яригдаж байгаа юм. Гэтэл та нар өнөөдөр хадгаламж, зээлийн хоршоог өргөжүүлээд, бусад төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг тийм юм руу орох гэж байна л даа. Хоршооны асуудал маань зөвхөн гишүүддээ үйлчлэх ёстой. Ийм байж байхад энийг бас ингэж хэт бас өргөжүүлэх гэж байгаа нь зөв үү?

Хоёрдугаарт, ер нь зүгээр энэ хадгаламж, зээлийн хоршооны асуудал энэ юу гэдэг юм бэ дээ хяналт, энд оролцож байгаа иргэдийн маань бас санхүүгийн боловсрол гэдэг юм уу энэ зүйлээсээ болоод зарим зүйлүүд бол бусдын өмнөөс хариуцлага хүлээлгэх хэмжээнд бас очиж байгаа зүйлүүд бас сонсогдоод байгаа байхгүй юу. Очоод байгаа юм. Тэгэхээр ийм зүйлүүдийг бас анхаарч энийгээ шийдсэн юм уу? Ер нь ашгийн төлөө бус хуулийн этгээдэд орж байгаа энэнээсээ дагахад ийм олон төрлийн үйлчилгээг үзүүлэх ийм зах зээлийн гэдэг юм уу өнөө маргаашийн тийм хэрэгцээ юу үүсээд байгаа билээ? Энэ бусад яг мэргэжлийн оролцогч буюу банк бус санхүү болоод банк руугаа л орж баймаар юм энэ мөнгөнүүд.

Миний ойлголтоор бол сүүлийн үед бол янз бүрийн мөнгөнүүд энэ хадгаламж, зээлийн хоршоо нэрээр ороод энэ чинь л улам бараг банк шиг болоод байгаа юм байна лээ шүү. Эх үүсвэрүүд тийм ойлгомжгүй. Тэгэхээр энэ зүйлүүдийг сайн бодсон юм уу? Янз бүрийн байдлаар нөгөө мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх буюу ФАТФ-ын энэ асуудал дээрх энэ шаардлагыг хангаж хяналт тавих энэ нөхцөл байдлаасаа ч гэсэн ер нь асуудлуудаа тооцож байгаа юу? Ийм байна. Тэгээд асуудлууд бас сөрөг юмнууд ч байдаг шүү дээ. Ашгийн төлөө бус учраас зах зээл дээр яг нөгөө мөнгө босгож ч юм уу зээл авахаас эхлээд хүндрэлтэй байдаг. Тэгэхдээ ингээд бодлогын зээлүүдэд хамрагддаг. Эсвэл тодорхой яг энэ хадгаламж зээлийн оролцогчид хувиа оруулаад ингээд явж байгаа. Энэ зэргээсээ бодоход уг нь ингэж өргөжүүлэх цаг үе нь мөн юм уу? Би энийг бол бас жоохон ойлгож өгөхгүй л байна л даа.

**Р.Сэддорж:** Санал хэлэв үү? Хариулт байгаа юу? Санал хэлэв үү? Хариулт 4 номер.

**Ц.Алтантуул:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг боловсруулахад бол Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос баталсан Хадгаламж, зээлийн хоршооны загвар хуулийг бол ашигласан байгаа. Хадгаламж, зээлийн хоршооны салбар бусад санхүүгийн салбараас ялгаатай нь хөдөлгөөн хэлбэрээр явдаг. Түвшин түвшиндээ улс орны тэр түвшинд, бүсийн түвшинд, дэлхийн түвшинд нэг дээвэр байгууллагад

оруулж зангиддаг. Тэр байгууллагуудаас нь бол зарчмууд болон загвар хуулийг нь батлаад улс орнууд өөрийн хуулиа шинэчлэхдээ бол тэр загвар хуульд орсон шинэ зохицуулалтуудыг бол ашиглаж салбараа бол хөгжүүлж явдаг. Яг энэ Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос баталсан сүүлийн загвар хуулийн хүрээнд бид нар хуулийн төслөө бол бичиж боловсруулсан байгаа.

Тэгэхээр бол ерөнхийдөө хадгаламж, зээлийн хоршоон дээр эрхэлж болдог үйл ажиллагаанууд ямар байдаг юм, ямар зарчим тавигддаг юм, удирдлага нь ямар байдаг юм, засаглалын тогтолцоо нь ямар байдаг юм гэдэг талаас нь бол хуулийн төсөлд бол тусгасан байгаа.

Засаглалын хувьд үзэх юм бол бүх гишүүдийн хурал, хяналтын зөвлөл, тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хороо болон ажлын алба гэсэн бүтцэд бол хадгаламж, зээлийн хоршоод хуваарилагдаж ажилладаг. Энэ дээр бол тодорхой шалгууруудыг тавьдаг. Мэргэжил боловсролын болон давтамжийн хувьд тэдэн сонгуулиа яаж хийх вэ, бүх гишүүдийн хурлаараа яаж тэрийгээ томилох вэ гээд бүх зохицуулалтууд нь бол нарийвчилсан байдлаар бол хуулийн төсөлд тусгагдсан байгаа.

**Р.Сэддорж:** Үүрийнтуяа гишүүн нэмж хариулъя.

**Д.Үүрийнтуяа:** Сайнзориг гишүүний ярьж байгаа санхүүгийн боловсрол багатайгаас болоод, хяналт сул байдгаас болоод эрсдэл үүсдэг, янз бүрийн мөнгө ч орж, гарч байхыг үгүйсгэхгүй гэдэг бол үнэн. Өнөөдөр байгаа нөхцөл байдал ийм л байгаа. Тийм ч учраас харин олон улсын жишигтэй нийцүүлж санхүүгийн хоршооны гишүүдийг чадавхжуулах, санхүүгийн хувьд бас энэ хоршооны үйл ажиллагааг аваад явчих хэмжээнд бэлтгэх, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, давхар даатгалын давхар хамгаалалтын системийг бэхжүүлэх үүднээс энэ хуулийн зохицуулалтыг оруулж байгаа. Энэ хуулийн хэрэгжих хугацаа дагаж мөрдөх журмын хуулиараа хугацаатай байгаа.

Тухайлах юм бол, дээвэр байгууллагын заалт гэхэд 29 оноос эхэлж хэрэгжинэ. Тодорхой хугацаагаар сунгаж байгаа. Үндсэн үйл ажиллагаа нь бол хадгаламж, зээлийн үйл ажиллагаа. Нэмэлтээр орох 3 үйл ажиллагаа бол энэ бэхжээд хадгаламж, зээлийн хоршоо чадавхжаад ирэхээр нэмэлт үйл ажиллагаа явуулах боломжийг нь бас нээж өгч байгаа. Богино хугацаагаар биш урт хугацаанд төлөвлөж харж байгаа гэсэн үг.

**Р.Сэддорж:** Сайнзориг гишүүн тодруулж асууна.

**П.Сайнзориг:** Хариултуудыг авлаа. Тэгээд бас анхаарна биз ээ. Ер нь хадгаламж, зээлийн хоршооноос бусад төрлийн хадгаламж, зээлийн хоршоо чинь аль хэдийн дээвэр холбоотой болчихсон. Энэ дээвэр холбоонд нь орж, гарах нь бас хүндрэлтэй юм байна лээ шүү. Яг хэсэг хүмүүс базчихсан. Энэ хүмүүсийн нөгөө аж ахуй эрхлэх үйл ажиллагаа дээр хориг саад болоод байгаа тохиолдлууд сонсогдоод байн лээ. Энэ гишүүнчлэлээр авахад хүртэл процесс нь ил тод бус, удаашралтай. Яг ийм юм болгоод хувиргачих вий.

Тэгээд бусад орнууд бол өөрсдийн ажлын байр олноор хадгалдаг тэр салбар дээрээ энэ хадгаламж, зээлийн хоршооны бодлогыг уялдуулдаг байхгүй юу. Тайланд жишээ нь зөвхөн хүнс гэдэг юм уу аялал жуулчлалын юман дээрээ л дэмжлэгийг тэр чиглэл рүү явдаг хадгаламж, зээлээ илүү дэмжиж байх жишээний.

Ер нь зүгээр бид хэд сайн бодохгүй бол ингээд маш олон зүгээр санхүүгийн дараа нь эрсдэлүүд болон энийг дагасан хохирогчид янз бүрийн юм болчих вий дээ гэдэг зүйл бол байна. Тэгээд энэ дээр бас бодолцож яахгүй бол бидэнд бас гашуун сургамжууд бий шүү. Энэ суурь асуудал буюу Иргэний хуулийн суурь асуудалтай уялдуулж байгаа учраас ажлын хэсэг энэ тэрээ сайн бас.../минут дуусав./

**Р.Сэддорж:** Саналыг хүлээж авлаа. Миний хувьд бол энэ хуулийг бол дэмжиж байгаа. Тэгээд энэ Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх ёстой чухал хууль бол хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж байна. Миний ойлгож байгаагаар тухайн сумд бол 1, хороонд бол ойролцоогоор 1, 2 ийм хадгаламж, зээлийн хоршоо тэгээд зөвхөн гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус, гишүүдээ таньдаг, тэгээд том банктай харьцаад байхгүй зээлийг шуурхай гаргадаг, зээлийн хүү бол банкнаас бага, мэдээж бага байж байж яана тийм ээ ийм л гэж ойлгоод байгаа зөв үү? Тэгээд энэ бол манай одоогийн Монголд бол хамгийн хэрэгтэй байгаа л ийм л зүйлийг ингээд бид хэлэлцээд яриад байгаа юм. Тэгээд хууль санаачлагчид энэ хуулиа зөв ойлгуулж, Монголбанктайгаа зөв ойлголцож энэ хууль, эрх зүйн хүрээнд нь ингээд хэлэлцүүлгийн явцад улам сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна. Энэ нутаг дэвсгэрийн харьяаллаараа байгаа юу? Тухайн сумын иргэд гэсэн юутай байгаа юу? Энэ дээр хариулт өгөөч. Сум, хорооны иргэд гэж байгаа юу?

4 номер.

**Ц.Алтантуул:** Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийн 15 дугаар зүйлд бол хоршооны гишүүнчлэлийн талаар бол зааж өгсөн байгаа. Гишүүнчлэлийг бол бид нар 4 бүлэгт хувааж үзэж байгаа. Нэгдүгээрх нь бол нэг байгууллагад ажилладаг, эс үгүй бол мэргэжил нэгтэй хүмүүс хадгаламж, зээлийн хоршоо байгуулж болж байна.

Хоёрдугаарт нь бол нэг хотод амьдардаг хүмүүс байж болж байна. Дараагийнх нь бол нэг хоршоо, нийгэмлэг, холбоонд гишүүнчлэлтэй байж болохоор, эсвэл нэг дүүрэгт, хотод үйл ажиллагаа эрхэлдэг хэлбэрээр гэсэн байдлаар 4 ангилж үзэж байгаа. Нутаг дэвсгэрийн хувьд ч, ажил мэргэжлийн хувьд ч байгаа, үйл ажиллагаа эрхэлж байгаа хэлбэрийн хувьд ч байгаа. Бүх боломжийг бол нээлттэй тавьсан байгаа.

**Р.Сэддорж:** Санал дээрээ бас хэлье. Ингээд гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Мандхай гишүүнээр тасалъя. Мандхай гишүүн.

**М.Мандхай:** Ер нь бол санхүүгийн хоршоо бол хөгжих ёстой гэдэг дээр бол би түрүүн бас байр сууриа илэрхийлсэн. Тэгэхдээ яг одоогийн байгаа энэ хуулийн төсөл дээр бас шүүмжлэлтэй ялт ч үгүй хандах хэрэгтэй байгаад байна. Үзэл баримтлал дээр бол ерөнхий үр дүн их бичсэн байгаад байгаа. Тэгсэн мөртөө энэ тоо баримтаа бол ерөөсөө баталгаажуулж яг баталж чадахгүй байгаад байгаа дээр бол бас шүүмжлэлтэй байгаад байгаа юм.

Жишээлбэл, зээлийн хүү буурна гэсэн хэдээр буурах юм? Санхүүгийн хүртээмж нэмэгдэнэ гэсэн яаж нэмэгдэх юм? Сүүдрийн эдийн засаг, мөнгө хүүлэгчтэй тэмцэнэ гээд хэлчихсэн байдаг. Энэ орон нутгийг хөгжүүлнэ гэж байгаа юм. Энэ нь өөрөө ямар ч тийм хэдэн хувиар, хэдий хугацаанд, хэдэн хүнд, ямар төгрөгөөр, ямар суурь гээд ингээд суурь түвшнээсээ буурах гэж байгаа гэдэг ийм хэмжүүр нь өөрөө тусгагдаагүй байгаа учраас эргэлзээ төрүүлээд байгаа байхгүй юу.

Тийм болохоор энэ хэрэгжилтийг энэ үнэлэх шалгуур үзүүлэлтийг өшөө сайжруулах хэрэгтэй. Тэгээд үндэслэлээ ер нь илүү баталгаажуулж, өшөө сайн судалгаа, тооцоотой орж ирмээр байгаад байгаа юм. Татвараас чөлөөлнө гэдэг их айхтар зүйлийг оруулаад ирсэн. Энэ өөрөө хамгийн том төрийн дэмжлэг юм. Төр ерөөсөө ямар ч энэ дээр дэмжлэггүй өөрсдөө ингээд хийчихнэ ээ гэсэн боловч бид нар хэрэв татвар ярьж л байгаа бол, татвараас чөлөөлж байгаа бол төрийн орлогыг бууруулах ийм асуудлыг хүртэл энд хөндөж байна гэсэн үг.

Тэгэхлээр энэ чөлөөлж байгаа асуудал бол өөрөө санхүүгийн шууд дэмжлэг гэж харж байгаа. Дээрээс нь энэ зах зээлийн өрсөлдөөнд бас давуу байдал олгож байгаа нь энэ өөрөө бас төрийн бодлого явж байгаа. Мөн хэрэв Санхүүгийн зохицуулах хороо дүрэм, журмыг зохицуулах гэж байгаа бол энэ чинь бас төрийн оролцоо шүү. Хяналтыг нь бас ялгаа байхгүй Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавих гэж байгаа бол энэ төр хэрэгжүүлэх гэж байна аа. Тэгэхээр ийм бүтэцтэй системийг төр оролцохгүй гэж хэлж тайлбар өгч байгааг нь би бол учир дутагдалтай байна шүү гэдгийг хууль санаачлагчид хэлмээр байгаа юм.

Эрсдэлийн асуудал байна. Хэрэв олон хоршоо дампуурвал яах вэ. Хадгаламж эзэмшигч хохирвол яах юм бэ? Санхүүгийн тогтолцоонд энэ итгэл алдарвал юу болох вэ? Яг хуучин хадгаламж, зээлийн хоршоонд үүсэж байсан энэ эрсдэлийн асуудлыг яг бодитой шинээр шинэчилж энэ шийдвэрлэж өгч байгаа эрсдэлийн энэ мах механизм өөрөө сул байгааг яг энэ хууль дээр бол сул байна гэж би бол хэлэх гээд байгаа юм. Тэгэхлээр ер нь бол энэ Хадгаламжийн даатгал, Тогтворжуулалтын сан ч гэдэг юм уу энэ оруулж ирж байгаа схем чинь зөв байна.

Гэхдээ эрсдэл бол байхгүй гэсэн бол ерөөсөө үг биш. Дээрээс нь эсрэгээрээ энэ бол өөрөө эрсдэлийг нь хуваарилах гэж байгаа л механизмыг л танилцуулаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр үр дүн, тоо, хэмжих, хэмжих үзүүлэлт, үүсэх гэж байгаа үр дагаврыг яаж эрсдэлийг нь хамгаалах вэ гэдэг механизмуудыг тооцоотой, судалгаатай, илүү нарийн боловсруулсан түвшинд дахиж энэ хуулийг танилцуулбал яасан юм бэ гэдэг саналыг бол би үгээрээ илэрхийлмээр байна.

**Р.Сэддорж:** Батсүмбэрэл гишүүн үг хэлнэ.

**Н.Батсүмбэрэл:** Би энэ хуулийн төслийг хэлэлцээд явах нь зөв гэж бодож байна. Тэгээд их олон юм энэ дотор бас гарч ирэх юм шиг байгаа юм. Ер нь улс төр, бизнес хоёр тос, ус хоёр шиг ялгарах ёстой гэдгийн нэг хэсэг нь энэ санхүүтэй холбоотой асуудал. Санхүүгийн тогтолцоо ялзралд орж хэсэг нөхдүүд санхүү, ялангуяа банк санхүүгээр дамжуулж улс төрийн шийдвэр гарагчдыг гартаа оролцуулж, өнөөгийн ялзрал, төрд үл итгэх байдал бий болчихоод байгаа юм. Зарим нэгэн том компаниуд байшин барьдаг, зам барьдаг, аялал жуулчлал хийдэг, хэвлэл, үйлдвэрлэл хийдэг, цаашлаад ТҮЦ ажиллуулдаг болсон. Тэгээд энэ нөхдүүд мөнгө хүүлдэг болсон. Энэ банк барилга барьдаг, банк санхүүгийн

байгууллага сугалаа сугалуулдаг, Барон Унгернын алтыг сугалаандаа явуулдаг байдлыг таслан зогсоох ёстой. Үүнийг энэ хуулийн зохицуулалтуудаар хийх ёстой.

Одоо энэ 126 нөхөр дотор тэдний хамаарал сууж байж болзошгүй байх. Тэр хүмүүсийн гар, хөл, үр төлүүдтэй нь хатуу ярих ёстой. Тэр хүмүүсийн үйл явдлыг, байр байдлыг энэ хуулийн хэлэлцүүлгээр бид нар ил тод харж, мэдэж, таньж авах ёстой юм. Ингэж олон түмэн түмний нүдэн дээр хэн нь хэн бэ гэдгийг үзүүлэх ёстой юм. Тийм учраас энэ хуулийг хэлэлцэх ёстой. Энэ ажлын хэсэгт нь орж ажиллаж гэж бодож байгаа Байнгын хороон дарга аа миний хувьд ийм байр суурьтай байгаа. Тэгээд энэ хуулийн төслийг бол хэлэлцэх ёстой, ярих ёстой.

Хадгаламж, зээлийн хоршооны ард жирийн иргэд хохирч байгаа хөрөнгөөрөө, өмчөөрөө, итгэл үнэмшлээрээ, ирээдүйгээрээ амь насаараа хохирч байгаа юм. Харин эрх мэдэлтнүүд, цөөхөн компаниуд хагартлаа баяжиж байгаа юм. Тэдний үр төлүүд нь энд ирж сууж байгаа юм. Ийм учраас энэ хуулийг даруй сайнаар нь баталж, энэ байгаа ялзарсан тогтолцоог цэгцлэх ёстой гэдэг би хатуу байр суурьтай байгаа. Түүний нэг хэсэг болсон Улаанбаатар хотын дарга нь эхлээд хадгаламж, зээлийн хоршоо байгуулдаг байдлыг таслан зогсоо цаашдаа. Тэр байдлыг цэгцэл, олон түмэнд зарла. Яагаад төсвийн мөнгөөр хадгаламж, зээлийн хоршоо байгуулж хороодыг, төрийн байгууллагыг, банк бус санхүүгийн байгууллага болгодог юм бэ? Энэ зөв юм уу, энэ шударга ёс юм уу, энэ төрийн ажил мөн юм уу? Энд Монголбанк хадгаламж, зээлийн хоршоо, нөгөө Санхүүгийн зохицуулах хороо хаана байсан юм? Яагаад нүдээ тагласан юм, яагаад амаа дарсан юм, юунаас болж энийг хараагүй юм? Энийгээ дүгнэх ёстой шүү дээ. Ийм учраас энэ хэлэлцүүлгийн өргөн хүрээнд хийх ёстой гэж бодож байна. Ийм учраас энэ хуулийг ярих ёстой гэж бодож байна.

**Р.Сэддорж:** Миний хувьд бас дэмжиж байгаа. Ингээд ашгийн төлөө бус байгууллага хүмүүс эвлэлдэж нэгдэж, хөрөнгөө өсгөөд тэндээсээ өөрийн гишүүддээ зээл өгөөд ингээд энэ үйл явц нь бол энэ хадгаламж, зээлийн хоршооны өмнөх Санхүүгийн хоршооны тухай хуулийн алдаа дутагдлыг залруулаад Санхүүгийн хоршооны тухай хууль ашгийн төлөө байсан бол ашгийн төлөө бус болгож ард иргэддээ нийцсэн, яг гишүүддээ үйлчилдэг ийм хуулийг л оруулж ирлээ гэж сайшааж байгаа юм.

Тэгээд эндээс бол өнөөгийн нийгэмд хамгийн хэрэгтэй зүйл энэ байгаа юм. Энэтхэг улс чинь 3 сая хоршоотой. Бараг 3 мянган ийм хоршоодын банктэй гэж ярьдаг. Тэгэхээр тэр бол ард иргэдийнхээ хамгийн ойрхон тийм санхүүгийн хэрэгсэл болж явж байгаа. Санхүүгийн байгууллага болж явж байдаг юм билээ. Тэгээд ийм өндөр банкны хүүтэй байгаа үед жижиг, дунд үйлдвэрлэл хөгжинө гэж ер нь байхгүй л дээ. Тэгэхээр энэ бол ийм үүднээс дэмжиж байгаа юм.

Гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдье.

1.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. дараагийн санал хураалт хамт өргөн мэдүүлсэн Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 8 санал хураалт явуулна. 2 дахь санал хураалт. Дахин уншъя хамт өргөн мэдүүлсэн Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Санхүүгийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Санхүүгийн санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа. Болохгүй юм байна өөр? Хууль санаачлагч болохгүй юм байна. Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

13.23 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*